

СОЁЛ БА ХҮНИЙ ЭРХ

Судалгааны тайлан

Гүйцэтгэгч: МУИС-ийн Антропологи, археологийн тэнхимийн ахлах багш

Г.Мөнх-Эрдэнэ

Захиалагч: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

Санхүүжүүлэгч: Ханнс Зайделийн сан

Агуулга

1. Удиртгал	4
2. Судалгааны арга зүй	7
3. Соёл ба хүний эрх, соёлын эрхийн тухай ойлголт олон улсын түвшинд	12
3.1. Соёлын эрхтэй холбогдох олон улсын гэрээний зохицуулалт	12
3.2. Соёлын эрх хэмээн ойлголтын тухай	16
4. Монгол Улсын эрх зүйн баримт бичигт соёлын эрхийн ойлголт туссан байдал	22
4.1. Соёлын эрхтэй холбогдох эрх зүйн баримт бичиг	22
4.2. Соёлын эрхийн тухай түгээмэл дурдагддаг кэйс	28
5. Монгол Улс дахь соёлын эрхийн өнөөгийн байдлын кэйс	34
5.1. Хуваалцдаг соёлын өвийн асуудал	34
5.2. Тайзны соёл уу эсвэл ахуйн соёл уу?	37
5.3. Үндэсний хэл боломж/саад	40
5.4. Хөгжлийн бодлого, төсөл, хөтөлбөр ба соёлын эрх	42
5.5. Зохиогчийн хийгээд оюуны бүтээлийн эрхийн зөрчил	45
6. Дүгнэлт, зөвлөмж	47
6.1. Дүгнэлт	47
6.2. Зөвлөмж	49
7. Ном зүй	51
8. Хавсралт	55
8.1. Соёлын салбарын мэргэжилтний ярилцлагын жишээ	55

1. Удиртгал

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс тус улс дахь соёлын эрхийн нөхцөл байдлыг тандан үзэх зорилгоор уг судалгааг захиалан хийлгэв. Судалгааг 2022 оны 10-11 дүгээр сард Улаанбаатар хотоор төвлөрөн, хийж гүйцэтгэсэн бөгөөд нийгэм-соёлын антропологийн судалгааны үндсэн арга болох оролцон ажиглах, хээрийн судалгаа, ярилцлагын арга зэргийг зохих түвшинд ашиглав. Манай улсад энэ төрлийн буюу бодлогын, хэрэглээний судалгаа хийхдээ тоон судалгааны арга болох асуулгын болон чанарын гэгдэх ярилцлагын арга зэргийг хослуулан хэрэглэх нь нэгэнт тогтсон стандарт болжээ гэхэд хэлсдүүлсэн болохгүй. Ийм нөхцөл байдалд антропологийн судалгааны аргын талаар ойлголт хомс, түүн дээр тулгуурласан ялгаатай санаа сэтгэгдэл гарах магадлалтай тул судалгааны аргын тухай илүү дэлгэрэнгүйг хоёрдугаар хэсгээс үзэх боломжтойг сануулъя.

Тус судалгааны ажлын даалгаврын дагуу **судалгааны үндэслэл** нь Монгол Улсад төдий л яригдахгүй байгаа ч олон улсын түвшинд өргөн хүрээнд хэлэлцэгддэг соёлын эрхийн ойлголтоос урган гарч буй юм. Манай улсын хувьд соёлын эрхтэй холбоотой заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд “Соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;” гэж тусгасан. Энэ заалтын үндэс нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал бөгөөд түүний 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй” (General Assembly of the United Nations 1948) гэсэн байдаг. Уг тунхаглалын үзэл санааг улам дэлгэрүүлж НҮБ-ийн Ерөнхий асамблэй 1966 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг батлан, 27 дугаар зүйлдээ “Угсаатан, шашны болон хэлний цөөнх оршин суудаг улсад эдгээр цөөнхөд багтдаг хүмүүст тийм бүлгийн бусад гишүүнийхээ хамтаар соёлоо баримтлах, шашнаа шүтэх, шашныхаа зан үйлийг үйлдэх, түүнчлэн эх хэлээрээ ярих эрхийг хорьж болохгүй” (General Assembly of the United Nations 1966a), мөн тус пактыг дагуулан баталсан Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактынхаа 15 дугаар зүйлд “Хүн бүр соёл, шинжлэх ухааны амьдралд чөлөөтэй оролцох, урлагийг эдлэх, түүний үр шимийг хүртэх эрхтэй” (General Assembly of the United Nations 1966b)

хэмээн тус тус зааж, зөвхөн хүний эрх бус соёлын эрхийн тухай олон улсын түгээмэл, стандарт ойлголтыг бүрэлдэх эхлэлийг тавьсан байна.

Соёл гэх ойлголтыг нэг мөр тодорхойлох бэрхшээлтэй байдаг. Соёлын тухай 1000 гаруй тодорхойлолт ч бий гэгддэг. Үүний адил соёлын эрх гэх ойлголтыг нэг юм уу нэг хэсэг тодорхойлолтоор төлөөлүүлэх боломж хомс гэдгийг соёлыг судалдаг судлаачид тэмдэглэсэн нь олон (жишээ нь, Eide 2001; Eide & Rosas 2001; Kukathas 1992; Levy 1997; Lury 2002; Müller 2017). Тиймээс Хүний эрхийн түгээмэл тунхаглалын өмнө дурдсан агуулга болох “Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй” (General Assembly of the United Nations 1948) хэмээн заалтыг голлох баримжаа болгон, хүн соёлынхоо амьдралд оролцох боломжтой, хүртээмжтэй, тохиромжтой байх эрхтэй гэсэн хүрээнд ашиглаж болно. Үүнээс гадна НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмж №21-д “Соёлын эрх нь түгээмэл, хуваагдашгүй, харилцан уялдаатай, харилцан хамааралтай хүний эрхийн салшгүй хэсэг мөн”, Хүний эрхийн зөвлөлд хүргүүлсэн Тусгай илтгэгчийн тайлангийн (A/HRC/14/36) “Олон судлаачдын онцолж байгаагаар соёл гэдгийг бүтээл, үйл явц, аж төрөх ёс гэж ойлгож болох бөгөөд угсаа гарал, хэл, шашин шүтлэгт хязгаарлагдахгүй холбоо, хамаарал гэсэн утга илэрхийлнэ” гэсэн хэсгийг давхар бодолцох шаардлага үүсэж байна.

Монгол Улсын хэмжээнд энэ төрлийн судалгаа хийх **хэрэгцээ шаардлага** нэгэнт бий болсон байна. Уг хэрэгцээ шаардлагын дараах маягаар тоймлож болно. Тэдгээр нь: Нэгдүгээрт, соёлын эрхийн талаарх академик болон бодлогын судалгаа хомс байна. Хоёрдугаарт, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт соёл, соёлын өв, соёлын үйл ажиллагаатай холбоотой бие даасан хэсэг төлөвлөгдөж, тэрхүү бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн суурь судалгаа, тооцооллыг хийж эхлээд байна. Гуравдугаарт, “Алсын хараа-2050”-тай холбогдуулан Монгол Улсын соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн суурь зарчим, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт зэрэг дагалдах бодлогын баримт бичиг батлагдан, хэрэгжиж эхлээд байгаа энэ үед соёлын бодлого, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл явцад хүний эрх, соёлын эрхэд суурилсан зарчим тусгах зайлшгүй шаардлага урган гараад байгаа юм. Дөрөвдүгээрт, дээрх бодлогын баримт бичиг хэрэгжихэд

монголын уламжлалт соёл, аж төрөх ёс болоод хүний эрхийн харилцан хамаарал ямар нөхцөл байдалд байгааг судалсан судалгаа хомс байгаа зэрэг юм.

Дээрх мэт хэрэгцээ шаардлагаас үүдэн тус судалгааны **зорилгыг** ажлын даалгавар доорх маягаар тодорхойлсон нь: "Монгол Улсын иргэдийн уламжлалт соёл, аж төрөх ёс буюу амьдрах хэв маяг нь хүний эрхэд нөлөөлж буй байдал, соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхийн баримт бичгийн судалгааг хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулахад оршино." Харин судалгааны энэхүү зорилгыг хангах үүднээс дараах үндсэн **зорилтыг** хэрэгжүүлэх юм. Тэдгээр нь : 1.Хүн бүр амьдарч буй газар зүйн байрлалаас үл хамааран соёлын үр шим, соёлын үйлчилгээг хүртэж чадаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх; 2.Нийгмийн зорилтот бүлэгт хамаарах эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нэн ялангуяа хурдан морь унаач хүүхдийн эрхийн хэрэгжилтийг уламжлалт соёлын харилцан хамааралд дүн шинжилгээ хийх зэрэг болно.

Тус тайлан нь нийт найман хэсэг, арван хоёр дэд хэсгээс бүтэж байна. Удиртгал хэсэг тайлангийн тухай ерөнхий мэдээлэл өгөх бол Судалгааны арга зүй хэсэг нийгэм-соёлын антропологийн судалгааны аргыг товч танилцуулахаас гадна бусад арга зүйгээс ямар ялгаа зөрүүтэй болохыг дэлгэрүүлэн тайлбарласан юм. Гуравдугаар хэсэгт соёлын эрх хэмээн ойлголт олон улсын гэрээ, пакт, конвенцад болон мэргэжлийн академик судалгаанд хэрхэн туссаныг тоймлож буй бол Дөрөвдүгээр хэсэгт Монгол Улсын хэмжээнд энэ сэдэв ямар нөхцөл байдалтай байгааг танилцуулж буй юм. Харин Тавдугаар хэсэгт манай улсад тэр бүр хэлэлцэхгүй, таньж мэдсэн нь бага байгаа соёлын эрхтэй холбогдох таван дэд сэдвийг авч үзнэ. Зургаадугаар буюу Дүгнэлт хэсэгт тус судалгаагаар олдсон судалгааны мэдээ, мэдээллийг дүгнэж, зөвлөмж гаргалаа. Наймдугаар хэсэг болох Хавсралтад нийгэм-соёлын антропологийн судалгаа, ярилцлагын аргын загвар болсон нэгэн ярилцлагыг хавсаргаж, түүгээр жишээ загвар болгон тус ухааны онцлогийг харуулах зорилго агуулсан болно.

2. Судалгааны арга зүй

Тус судалгааны сэдвээс үүдэн чанарын судалгааны арга тэр дундаа ярилцлага, түлхүүр мэдээлэгчид төвлөрөх, хоёрдогч эх сурвалжтай ажиллах гэсэн үндсэн гурван аргыг сонгон асуудлаа судаллаа. Судалгааны ажилд өгөгдсөн хязгаарлагдмал хугацаанаас бол антропологийн судалгааны үндсэн арга болох оролцон ажиглах арга зүйг бүрэн дүүрэн ашиглах боломжгүй байсан ч цугласан мэдээллийн чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж тооцлоо. Уг судалгааг монголд тогтсон жишгийн дагуу асуулгын аргаар судлах боломж хомс гэж үзсэн тул түлхүүр мэдээлэгчтэй тулж ажиллах, тэрхүү мэдээлэгчтэйгээ 1-3 удаа уулзаж, ярилцан ярилцлагын арга ашиглан мэдээллээ цуглуулав. Ийн цуглуулсан мэдээллээс шалгаж, нягтлах хэрэгтэй гэж үзсэн хэсгээ хоёрдогч эх сурвалжаар давхар баталгаажуулсан болно.

Түлхүүр мэдээлэгчийн хувьд монголын соёлыг сүүлийн 5-30 жил судалж буй дотоод гадаадын судлаач, соёлын мэргэжилтэн, экспертүүдэд төвлөрсөн юм. Гадаадын гэдэгт Япон улсын Токиогийн гадаад хэлний их сургууль, Австрали улсын Мэйлбүрний их сургууль, Их Британийн Окфордын болон Кэмбрижийн их сургуулийн судлаач, докторын оюутан зэрэг зургаан мэргэжилтнийг багтаав. Тэдэнтэй ихэвчлэн онлайн орчинд, Teams, Zoom, Facetime, Google meet зэрэг аппликэйшн, программыг ашиглан холбогдов. Энэ нөхцөлд өмнө нь Монгол Улсад төдий л хэрэглэгдэж байгаагүй судалгааны нэгэн аргын туршиж үзсэн нь дижитал угсаатны зүй (digital ethnography) байлаа. Энэ аргын хамгийн энгийнээр "компьютер, дижитал технологи ашиглан мэдээлэл цуглуулах" (Varis 2015, 55) гэж тодорхойлж болох юм. Ташрамд уг судалгааны арга үр дүнтэй байсан гэж дүгнэн, дараа дараагийн судалгаанд ашиглах боломж бүрэн байгааг илрүүлэв. Дотоодын гэдэгт МУИС, ШУТИС, СУИС, ШУА зэрэг их сургууль, судалгааны байгууллагад ажиллаж, соёлын салбарын судалгаа хийж буй 9 мэргэжилтэнтэй хийсэн ярилцлага багтаж буй юм. Түүнчлэн үндэсний цөөнх болсон Казак түмний соёлын эрхийн тухай тодруулах үүднээс МУИС, ШУТИС-д суралцаж буй зарим казак оюутны кэйсийг ашиглав. Мөн Монголын Криминологичдийн Холбооны захиалгаар 2021-2022 онд хийсэн "Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн эрх зүйн антропологийн судалгаа"-ны тайлан тэр дундаа тус судалгааны судлаачдын Баян-Өлгий аймагт хагас сар хийсэн хээрийн

судалгааны тэмдэглэл, эх хэрэглэгдэхүүнийг казак иргэдийн соёлын эрхийн нөхцөл байдлыг тодруулахад нэмэлтээр ашигласан болно.

Өмнө дурдсанчлан монголд хэвшил болсон асуулгын аргыг сонгоогүй нь антропологийн ухааны онцлогоос болж буй юм. Тиймээс нэн тэргүүнд нийгэм-соёлын антропологийн судалгааны харах өнцөг, хандлагын тухай ерөнхий ойлголт өгөх хэрэгтэй болно. Учир нь энэхүү судалгааны тайлантай төстэй бодлогын болоод хэрэглээний судалгаа хийх үед ялгаатай салбар ухаануудын онол арга зүй, хандлагыг тус тусад нь авч үзэх хэрэгцээ үүсдэг. Тэр бүр захиалагч, санхүүжүүлэгч, хянагч, уншигч тал нийгэм-соёлын антропологийн ухааны онол, арга зүй, хандлагын талаар гүнзгий ойлголттой байх нь ховор тул ийм байдал үүсдэг болов уу. Нөгөө талаас судалгаа гүйцэтгэж буй антропологичид ч гэсэн антропологийн мэргэжлийн ойлголтыг өөр мэргэжилтэй хүнээс "шаардах" нь ч өрөөсгөл юм. Тиймээс үүсэх ойлголцлын зөрүүнээс сэргийлэх үүднээс суурь тайлбар хийх нь зайлшгүй болоод байна.

Антропологийн ухаан үүссэн цагаасаа өнөөг хүртэл бусад нийгэм-хүмүүнлэгийн ухааны судалдаг сэдэв, харах өнцөг, перспективээс тодорхой ялгаатай байсаар байна. Энэхүү хандлагыг "доороос дээш чиглэсэн" гэж ерөнхийлөн тодорхойлж болно. Антропологийн үүднээс аливаа зүйлийг судлахдаа заавал мэдээллийн анхдагч эх сурвалжаа өөрөө бэлддэг байхыг шаардаж, хоёрдогч эх сурвалжаас тодорхой зай барихыг чухалчилдаг. Иймээс аль нэг ард түмний соёлыг судалж буй антропологич тухайн хүмүүсийн дунд урт хугацаанд амьдран, мэдээлэгчтэйгээ ихэд ойр дотно танилцан, өөрийн соёлыг юу гэж ойлгож байна, ямар утга учиртай гэж үзэж байна, юуг нь болохгүй гэж байна гэдгийг өөрийн биеэр ажиглан бас сурвалжлан тогтоодог. Улмаар тэрхүү ойлголт нь нийгэм-хүмүүнлэгийн ухааны онол, хандлагатай хэр зохицож эсвэл зөрчилдөж байна, улмаар өнөөх онол нь тэр ард түмний жишээгээр батлагдаж, няцаагдаж буй эсэхийг нягталдаг. Өөрөөр хэлбэл антропологи судалж буй сэдвээ аль нэг онолоор тайлбарлах эсвэл нэг онол, хандлага уншаад түүндээ таарсан жишээ хайх бус байгаа, тогтсон онол хандлага нь бодит хүний амьдрал, нийгэм-соёл, ахуйд таарч байна уу гэдгийг шалгаж, нягталж байдаг гэсэн үг. Онолоо тэргүүнд тавин хүний амьдрал, соёлыг тайлбарлах бус баримтаа тэргүүнд тавьж аль нэг нийгмийн ухааны онолыг шүүн тунгаах шинжтэй гэсэн санаа юм.

Харин бусад нийгмийн ухаан болох социологи, улс төр, эдийн засаг, шашин судлал магадгүй эрх зүйн судалгаа аль нэг судалгааны хандлага, онолыг нэгдүгээрт барьж тухайн судалж буй асуудлаа тэрхүү онол хандлагатай хэр зохицож буйг тунгаах хандлагатай байдаг. Уг хандлагыг "дээрээс доош чиглэсэн" гэж хэлж болно. Жишээ нь, эдийн засгийн ухаанд эдийн засгийн хууль гэгч зүйлийг ихэд чухалчилдгийн нэгэн баримт нь "зах зээлийн хууль, зарчим" гэх ойлголт хэллэг юм. Магадгүй зарим талаар эдийн засгийн ухаан нэрийн дор зөвхөн зах зээлийн эдийн засгийн талаар ярьдаг ч судлаачид байж болно. Баримтаар бол эдийн засаг гэж тусдаа ойлголт, зах зээлийн эдийн засаг гэж тусдаа ойлголт юм. Өөрөөр хэлбэл нэгэн "зах зээлийн хууль" гэж хүний эдийн засгийн амьдралд үнэмлэхүй аль эсвэл ихэнх тохиолдолд үйлчилдэг "жам ёсны" зүйл байх бөгөөд хүний үйлдэл тэрхүү хуульд зохицож, зөрчилдөж байгаа тухай асуудлыг судална гэсэн үг. Ингээд тэрхүү хуулиар тайлбарлагдахгүй эсвэл тайлбарлахад хэцүү аливаа үзэгдлийг эдийн засгийн бус сэдэв эсвэл эдийн засгийн ухаан судлах хэрэггүй сэдэв гэх зэргээр хасан, танаж, орхигдуулж байдаг.

Гэтэл антропологийн үзлээр бол тэрхүү хуулиар тайлбарлах аргагүй ч хүний эдийн засгийн амьдралын салшгүй хэсэг болсон, чухал үүрэгтэй олон үзэгдэл энэ мэт хаягдан, судалгаа шинжилгээний гадуур орхигдоод байдаг сул талтай ажээ. Үүний нэгэн жишээ бол "бэлэг солилцох" явдал юм. Хүний амьдралаас бэлэг солилцох үйлдлийг аваад хаячихвал юу тохиолдох бол? Энэ үйлдэл утга учраар баялаг, шүтлэг, зан үйл, нийгмийн зохион байгуулалт, нийгмийн байр суурь, өөрийгөө илэрхийлэх зэрэг олон чухал ойлголттой холбогддог зүйл. Харин үүний эдийн засгийн учир холбогдлыг эдийн засгийн ухаан тэр бүр сонирхож үздэггүй. Энэ мэт эдийн засгийн ухаан төдий л анхаардаггүй эдийн засгийн олон сэдвийг эдийн засгийн антропологи хэмээх салбар ухаан судалж байдаг. Үүний адилаар манай эрх зүйн судалгаа хууль, эрх зүйн баримт бичигт хэт төвлөрөн, тэдгээр зүйл хүний нийгмийн амьдралыг зохицуулдаг мэтээр ханддаг байж болно. Гэтэл бичигдсэн хуулиас гадна бичигдээгүй зүйлс, хов жив, нийгмийн сүлжээний пост, заншил суртахуун, ёс зүй гээд олон зүйл нийгэмд хэм хэмжээ тогтоож байдаг.

Өөр нэгэн жишээ бол шашин судлал гэх ухаан болоод шашны антропологи хоёрын сонирхон судалдаг сэдэв байна. Шашин судлал дэлхийн томоохон, олон дагагч, шүтэгч нартай шашныг илүү анхаардаг бол шашны антропологи нь

цөөхөн хүн шүтдэг, магадгүй шашны биш, мухар сүсэг, буруу номын, ёс бусын хүч зэрэг нэг хоч зүүсэн олон зүйлийг судалдаг. Тэр бүхэн хүний амьдралд тодорхой үүрэгтэй, утга учиртай байдаг. Магадгүй хэчнээн судлаач тэр бүхнийг "хэрэггүй", устаж буй, үеэ өнгөрөөсөн, "орчин үед" таарахгүй зэргээр хэлж болох ч тэр бүхэнд хүний амьдралд байсаар л байна, үүргээ гүйцэтгэсээр л байна. Тиймээс антропологийн үүднээс аливаа соёлын үзэгдлийг ойлгох, тайлбарлах нь чухал болохоос (илүү дэлгэрүүлж Geertz 1973-ээс уншина уу) зөв, буруу гэж шүүх, яллах, нэр хоч өгөх нь чухал бус гэж үздэг.

Удаах анхаарах зүйл бол арга зүйтэй холбоотой асуудал. Монгол Улсад судалгааны аргыг илүү тоон аргатай тэр дундаа асуулгын аргатай холбож ойлгох хандлага хүчтэй тогтсон гэж болно. Зарим тохиолдолд асуулгын аргатай хамт ярилцлага, фокус бүлгийн ярилцлага зэрэг аргыг хослуулан ашиглах нь бий. Ингэхдээ судалгааны түүвэрлэлт хэмжээ, төлөөлөх чадвар гэдэгт тун их ач холбогдол өгдөг. Судалгааны тоон аргын мөн чанараас болж, мэдээллийн чанар, бодит байдлыг хангалттай хэмжээнд байлгах үүднээс ингэхээс өөр арга байхгүй. Үнэхээр ч урьд уулзаж байгаагүй хүнээр хэдэн минутад багтаан асуулга бөглүүлж авах, хэдэн минутаас хэдэн цаг хүртэлх хугацаанд ярилцлага хийж мэдээлэл цуглуулсан үед мэдээллийн чанар, төлөөлөх чадвар байнга яригдах нь зүйн хэрэг. Түүвэрлэлтээ чанартай хийсэн судалгааны үед хэдий богинохон хугацаанд хүнтэй уулзан, мэдээлэл цуглуулах ч төлөөлөх чадвар хангалттай байдаг. Гэвч эргээд энэ аргын сул тал нь мэдээлэгчтэй гүнзгий харилцаа тогтоодоггүй, мэдээллийн чанартай холбоотой бэрхшээл үүсэх гээд байдаг оршино (Bernard 2017, 20). Антропологи судалгааны түүвэрлэлт хийх ч түүнд хэт анхааралгүй мэдээллийн чанараа чухалчлан, түлхүүр мэдээлэгчтэйгээ илүү гүн гүнзгий харилцаа тогтооход ихэнх цагаа зарцуулдаг. Нэгэнт ойр, дотно гүнзгий харилцаа тогтоосон мэдээлэгчийн мэдээллийн чанар харьцангуй сайн байдаг. Ялангуяа эмзэг, хувийн, нууц гэж үзэгддэг асуудал, бидний тохиолдолд бол соёлын эрхийн зөрчил гэх маргаантай сэдвийн талаар мэдээлэл ийм нөхцөлд л гарч ирдэг. Тиймээс антропологи хээрийн судалгаа, ярилцлагаас гарч ирсэн мэдээллээ бодитой, хангалттай чанартай гэдгээ нотлохын тулд түүвэрлэлтийн хэмжээ чухалчлан ярьдаггүй. Гэвч энэ нь антропологийн судалгаа түүвэрлэлт бага хийдэг, цуглуулсан мэдээлэл нь төлөөлөх чадвар бага гэсэн үг бишийг санаарай.

Гуравдугаарт анхаарах зүйл нь антропологийн бичлэгийн хэв маяг юм. Магадгүй манай улсад "тогтсон" эрдэм шинжилгээний бичлэгийн үүднээс үзэх юм

бол антропологийн олон судалгаа уран зохиолын бичлэгтэй төстэй санагдах боломжтой. Антропологич бид урьд өмнө нь бодлогын болон хэрэглээний судалгаа хийх үед захиалагчийн зүгээс антропологийн бичлэгийн хэв маягтай холбоотой санал гарч байсан тохиолдол бий. Уг ухаан нь өөрөө мэдээллийн чанарт анхаардаг, түүх өгүүлэхийн (story telling) ач холбогдлыг чухалчилдаг тул олны мэдэх кэйс судалгаатай төстэйгөөр аль нэг жишээ, хэн нэгний тухай өгүүлэмжээр төлөөлүүлэн судалж буй асуудлаа тодруулан тайлбарлаж, идэвхгүй дүрслэх арга маягаас зайлсхийдэг (Bernard 2017) нь зарим тоон судалгааны аргыг чухалчилдаг судлаачдад ойлгомжгүй санагдах тохиолдол бий. Өөрөөр хэлбэл аль нэг антропологийн судалгааг нээж үзэхэд угсаатны зүй буюу аль нэг хүний хувийн амьдралын түүх эсвэл ямар нэгэн сэдвийн тухай нийгэмд өрнөсөн мэдээллийг мэдээ дамжуулж буй мэт энгийнээр өгүүлж эхлэн цаашлаад судалж буй асуудлынхаа гүн лүү орох нь түгээмэл байдаг гэсэн үг.

Ингээд энэхүү товч хэсэг антропологийн судалгааны арга, онол, бичлэгийн онцлог, ялгаа зөрөөний тухай товч ойлголт өгсөн гэж үзэн дараагийн хэсэгт соёлын эрхийн тухай ойлголт олон улсын эрх зүйн баримт бичигт хэрхэн туссан байдгийг авч үзье.

3. Соёл ба хүний эрх, соёлын эрхийн тухай ойлголт олон улсын түвшинд

3.1. Соёлын эрхтэй холбогдох олон улсын гэрээний зохицуулалт

Соёлын тухай анхны тодорхойлолтын нэгийг Английн антропологич Эдвард Тайлорын *Хүй нэгдлийн соёл* (Primitive Culture) зохиолдоо “соёл хийгээд иргэншил гэдэг нь угсаатны зүйн өргөн утгаараа мэдлэг, сүсэг бишрэл, урлаг, ёс суртахуун, хууль ёс болон хүний нийгмийн гишүүн байхад шаардлагатай зан авир, дадал чадварыг нийлүүлсэн нэгэн бүхэл цогцолбор юм” (Тайлор 1871, 1) хэмээсэн нь өнөө ч антропологийн төдийгүй нийгмийн ухаанд өргөн дэлгэр эшлэгддэг тодорхойлолт болжээ. Зөвхөн эрдэм шинжилгээ төдийгүй хууль эрх зүйн заалт, олон улсын байгууллагын бодлогын баримт бичигт ч соёлын тухай энэ тодорхойлолтын агуулга их бага хэмжээгээр давтагдаж байдаг. Тэгэхээр хамгийн энгийнэндээ соёлын эрх гэдэг нь энэ тодорхойлолтод дурдагдаж буй зүйлсийг чөлөөтэй илэрхийлэх, үзүүлэх явдал гэж ойлгож болно.

Соёлын эрхийн тухай үндсэн хийгээд анхдагч ойлголт нь албан ёсоор Хүний эрхийн түгээмэл тунхаглалтай холбогдоно. "Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг" Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ. Тунхаглалын **22 дугаар зүйлд** "Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй" **27 дугаар зүйлд** "Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй" Мөн "Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй" (General Assembly of the United Nations, 1948) гэж тус тус заасан байдаг.

Дээрх санаачилгын даган НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт-д" бидний ярьж буй эрхийн асуудлыг тодорхой зааж "... Энэхүү Пактад оролцогч улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд тунхагласан зарчмын дагуу хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөн болохыг анхааралдаа авч, ... Хүний эрхийн түгээмэл Тунхаглалд зааснаар хүн бүр эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс төр, иргэнийхээ эрхийн адил эдлэх нөхцөлөөр гагцхүү хангагдаж байж л улс төр, иргэний эрх чөлөөгөө эдэлж, айх аюулгүй, гачигдах зовлонгүй байх чөлөөт бие хүний эрхэм зорилго биелэгдэхийг хүлээн зөвшөөрч, ... дор дурдсан зүйлийг тохиролцов: **1 дүгээр зүйл** Бүх ард түмэн өөрөө засан тохинох эрхтэй. Энэхүү эрхийнхээ дагуу тэд улс төрийн статусаа чөлөөтэй тогтоож, эдийн засаг, нийгэм, соёлоо чөлөөтэй хөгжүүлнэ... **27 дугаар зүйл** Угсаатан, шашны болон хэлний цөөнх оршин суудаг улсад эдгээр цөөнхөд багтдаг хүмүүст тийм бүлгийн бусад гишүүнийхээ хамтаар соёлоо баримтлах, шашнаа шүтэх, шашныхаа зан үйлийг үйлдэх, түүнчлэн эх хэлээрээ ярих эрхийг хорьж болохгүй" (General Assembly of the United Nations, 1966a) гэдгийг тодорхойлжээ.

Мөн тус өдөр Ерөнхий Ассамблейгаар баталсан "Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт-д" дээр ярьсан эрхээ улам дэлгэрүүлэхийн зэрэгцээ нарийвчлан тодорхойлж "...Энэхүү Пактад оролцогч улсууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмын дагуу хүн төрөлхтний бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс болохыг анхааралдаа авч, ... эдгээр эрх нь хүнд угаас заяасан нэр төрөөс үүдэн гарч байгааг хүлээн зөвшөөрч, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд зааснаар хүн бүр эдийн засаг, нийгэм соёлын эрхээ улс төр, иргэний эрхийн адил эдлэх нөхцөлөөр хангагдсан үед л айх аюулгүй, гачигдах зүйлгүй байх чөлөөт бие хүний туйлын хүслэн биелэгдэхийг хүлээн зөвшөөрч, ... дор дурдсан зүйлийг тохиролцов: **15 дугаар зүйл** 1. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр дараах эрх эдлэхийг хүлээн зөвшөөрнө: (a) соёлын амьдралд оролцох; (b) шинжлэх ухааны дэвшлийн үр дүнг ашиглах, түүнийг хэрэглэх; (c) өөрийнхөө туурвисан

шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны аливаа бүтээлтэй холбогдон үүссэн ёс суртахууны болон эд материалын ашиг сонирхлыг хамгаалуулах. 2. Энэхүү Пактад оролцогч улсуудаас энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс авч явуулбал зохих арга хэмжээнд шинжлэх ухаан, соёлын ололтыг хамгаалах, хөгжүүлэх, дэлгэрүүлэхэд шаардагдах арга хэмжээ багтана. 3. Энэхүү Пактад оролцогч улсууд шинжлэх ухааны судалгааны болон уран бүтээлийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардагдах эрх чөлөөг хүндэтгэх үүрэгтэй. 4. Энэхүү Пактад оролцогч улсууд шинжлэх ухаан, соёлын салбарт олон улсын харилцаа, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх нь үр ашигтай гэдгийг хүлээн зөвшөөрч байна" (General Assembly of the United Nations, 1966a) гэсэн байна.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдан, түүнд Монгол Улс нэгдэн орсон цагаас хойш тус улс дээрхийн мэт олон улсын, хүн төрөлхтний түгээмэл үнэл зүйл болсон хүний эрхийн болоод соёлын эрхийн олон гэрээ, конвенц, баримт бичиг нэгдэн оржээ. Түүний нэг жишээ нь ЮНЕСКО 2003 онд Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг баталсан юм. Тус конвенц дээрх гурван бичиг баримтыг үндэс болгон "Хүн төрөлхтний соёлын биет бус өвийг хамгаалахад чиглэсэн бүх нийтийн хүсэл зориг болон нийтээр зовних эрмэлзлийг ухамсарлаж; ... Хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүмүүсийн соёлын биет бус өвийг бүтээх, хамгаалах, хадгалах, сэргээн бүтээхэд чухал үүрэг гүйцэтгэж, соёлын төрөл зүйлийг баяжуулан, хүний бүтээл туурвилыг тэтгэн дэмжиж байдгийг хүлээн зөвшөөрч;... Соёлын өвийг хамгаалахад чиглэсэн эрх зүйн баримт бичиг, ялангуяа Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай 1972 оны конвенцыг боловсруулахад ЮНЕСКО-ийн үйл ажиллагаа их ач холбогдолтой болохыг тэмдэглэж; ... Өнөөгийн нөхцөлд соёлын биет бус өвийг хамгаалах талаар эрх зүйн хүчин төгөлдөр олон талт баримт бичиг байхгүй байгааг цаашид тэмдэглэж..." (ЮНЕСКО 2003) гэх мэтчилэн зааж өгсөн байна. Монгол улс тус конвенцид 2005 онд нэгдэн орсноор тус баримт бичиг дурдсан заалтыг нутаг дэвсгэр дээрээ хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн юм. Иймээс Соёлын тухай хуулиа Соёлын өвийн тухай хууль болгон өөрчлөн баталж, ЮНЕСКО-гийн Биет бус соёлын өвийн жагсаалтад соёлын өвөө бүртгүүлэх уралдаан өрнөөд байна.

Уг конвенцын дараа буюу 2005 онд ЮНЕСКО "Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих" тухай конвенцыг баталсан бөгөөд Монгол улс 2007 онд нэгдэн оржээ. Тус баримт бичигт "... Биет болон биет бус

баялгийн эх сурвалж болох уламжлалт мэдлэг, ялангуяа уугуул иргэдийн мэдлэгийн тогтолцоо, тогтвортой хөгжилд оруулах тэдгээрийн хувь нэмрийг ач холбогдол болон тэдгээрийг зохих ёсоор хамгаалах, хөхиүлэн дэмжих шаардлагатайг хүлээн зөвшөөрч; ... Соёлын илэрхийллийн олон төрлийг агуулгыг нь оролцуулан хамгаалахад чиглэсэн арга хэмжээг, ялангуяа соёлын илэрхийллүүд нь устаж үгүй болох, эсхүл ноцтой аюулд учрах нөхцөл байдалд авах шаардлагатайг хүлээн зөвшөөрч; ... Соёл нь нийгмийн эв нэгдэл, ялангуяа эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, үүргийг дээшлүүлэхэд ач холбогдолтой болохыг тэмдэглэн; ... Соёлын олон төрөл нь үзэл санаагаа чөлөөтэй илэрхийлэх хэлбэрээр бэхжиж, соёл хоорондын тогтмол солилцоо, харилцан үйлчлэлээр тэтгэгддэг болохыг ухамсарлан; ... Чөлөөтэй сэтгэх, илэрхийлэх, мэдээлэх болон мэдээллийн олон төрлийн хэрэгсэл нь нийгэмд цэцэглэн хөгжих боломжийг соёлын илэрхийллүүдэд олгодог болохыг дахин нотлон; ... Соёлын илэрхийллийн олон төрөл, тэр дундаа уламжлалт соёлын илэрхийллүүд нь иргэд болон ард түмэнд үзэл бодол, үнэт зүйлсээ илэрхийлэх, бусадтай хуваалцах боломжийг олгодог чухал хүчин зүйл гэдгийг хүлээн зөвшөөрч" (ЮНЕСКО 2005) зэргээр соёлын эрхийн асуудал чухал болохыг, тус эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой анхаарууштай алхам, хамрах хүрээтэй холбогдох зүйлсийг дэлгэрэнгүй дурдаж өгсөн байдаг.

Ийнхүү олон улсын түвшинд зөвхөн соёлын гэлтгүй хүний эдийн засаг, нийгмийн эрх тодорхой зорилго, чиглэлтэй болж, хүн төрөлхтний нийтийн үнэт зүйл болоод байна. Улмаар энэ ойлголт хөгжлийн бодлого төлөвлөлттэй ч холбогдож, Амартяа Сэний "боломжтой байдал" (capability) хэмээх ойлголтод ч нөлөөлж, 1980-1990 онд Хүний хөгжлийн индекс зэрэг хэмжигдэхүүн гарахад нөлөөлжээ. Цаашлаад энэ санаа Сэний (1999) "Хөгжил бол эрх чөлөө" (Development as freedom) гэх бүтээлээр улам түгж, эзэндээ Нобелийн шагнал ч авчирсан бөгөөд Мянганы хөгжлийн зорилт, Тогтвортой хөгжлийн зорилт зэрэг бодлого, санаачилгад тусаж, нийтээрээ зорих чиглэл болоод байна.

3.2. Соёлын эрх хэмээн ойлголтын тухай

Энэ хэсэгт соёлын эрх хэмээх ойлголтын тухай Барууны тэр дундаа англи хэлээр хэвлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийг тоймлон өгүүлэх юм. Энэ талаар олон тооны судалгаа бий бөгөөд нэгэнт антропологийн судалгааны аргаар тус сэдвийг судалж буй тул илүү антропологийн судалгааг сонгож, голлон авч үзсэн

гэдгийг тодруулах хэрэгтэй. Мөн яагаад заавал англи хэлээрх судалгааг сонгож буйгаа тайлбарлах нь зүй. Манай улсын их сургууль эрдэм шинжилгээний байгууллагууд өндөр төлбөр мөнгөнөөс нь болж Барууны эрдэм шинжилгээний онлайн хэвлэлийн газрын эрхийг авч чадахгүй байх, эргээд гадаад хэлний чадвараас шалтгаалан тэр бүр дээрх мэдлэгийн баазад буй бүтээл, судалгаатай танилцаж чадахгүй байдаг талтай. Учир ийм тул соёлын эрхийн тухай англи хэлээр хэвлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийг өргөн олон танилцуулах нь зохих хэрэг тустай алхам гэж үзлээ.

Уламжлал ёсоороо бол антропологийн ухаан Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг, түүний түгээмэл гэгдэх мөн чанарыг эсэргүүцэн, үгүйсгэж байсан юм. Америкийн антропологийн холбоо эсэргүүцлийн бичиг хүртэл боловсруулан олон түгээж байсны учир бол антропологийн гол судлагдахуун болох соёл гэх зүйл нь өөрөө харьцангуй шинжтэй, нэг соёлыг нөгөө соёлын хэмжүүрээр шүүх, дүгнэх, дүрслэх боломжгүй гэсэн суурь зарчимтай зөрчилдөж байснаас болсон юм. Гэвч өнөө цагт заавал ийм эсрэгцэл гаргаж, хатуу ширүүн шүүмж өрнүүлэх шаардлага зайлшгүй бий юу гэдгийг тунгааж үзэх хэрэгтэй. Антропологичдын үзэж байсанчлан ямар нэгэн хуулийн заалт, ойлголт газар бүр харилцан адилгүй хэрэгжиж байгаа шиг "хүний эрх" гэх ойлголт ч өөр өөрөөр тайлбарлагдаж, хэрэглэгдэж буй судалгаа хэвлэгдэж болжээ.

Прэйш (1996) антропологид хүний эрхийн ойлголттой тэр бүх орооцолддоггүй таван шалтгааныг тайлбарласан байна. Түүний үзлээр бол тэдгээр нь нэгт, өнөө цагт антропологичид саяхнаас л хүний эрхийн асуудалтай холбогдох олон судалгаа хийх болсон гэнэ. Жишээ нь, уугуул иргэдийн эрхийг хамгаалах гэх мэт. Хоёрт, хэдий улс төрийн хийсвэл хүний эрх гэсэн ойлголтыг бүтээхэд антропологичид оролцоогүй ч өөрсдийнхөө судалдаг жижиг бүлэг, тосгон, хүй бүлгийн эрхийн тухай олон тунхаг, код, баримт бичигт саяхнаас л идэвхтэй оролцох болсон гэнэ. Гуравт, антропологичид хээрийн судалгаагаа амжилттай хийхийн тулд тэр бүр судалж буй соёлынхоо төр, эрх мэдэлтэй хэсгийн үйл ажиллагааг хатуу шүүмжлэх, тэдэнтэй хэт их орооцолддоггүй байхыг хичээх болсон гэнэ. Дөрөвт, хэдий антропологичид хүний эрхийн асуудалд идэхтэй оролцох болж байгаа ч НҮБ зэрэг хүчирхэг байгууллагад одоо болтол хууль, эрх зүйн судлаачид ноёрхож байгаа ажээ. Тавт, антропологичдын дунд НҮБ зэрэг үндэстэн дамнасан томоохон байгууллага хэмжээ, цар хүрээнээсээ үл хамааран хэрэгжүүлдэг бодлого нь тэр бүр амжилттай байдаггүй гэсэн итгэл

үнэмшил байдаг гэжээ. Гэвч дээрх бүгдээс илүү антропологи соёлын харьцангуй байдлын онол, зарчмаа илүү чухалчилдаг тул хүний эрхийн түгээмэл гэх чанар итгэдэггүй гэсэн байна.

Судлаач Вилсон (1997) өөрийн эмхэтгэсэн бүтээлдээ хүний эрх ёс суртахууны гэхээсээ илүү нийгмийн харилцаанаас гарч ирсэн ойлголт гэдгийг онцолж, энэ нөхцөлд хүний эрх тухай ярихдаа олон төрлийн харилцаа тэр дундаа үндэсний, орон нутгийн, үндэстэн хоорондын хуулийн харилцаа зэргийг авч үздэг байх ёстойг сануулжээ. Ингэж үзвэл хүний эрх гэдэг түгээмэл шинжтэй (universal) атал соёл харьцангуй (relativist) шинжтэй тул энэ хоёр ойлголт эсрэгцдэг, тиймээс соёлын ялгаатай байдлыг чухалчлан үзэх хэрэгтэй гэсэн байна. Ингэж мэтгэснээрээ тэрээр хүний эрх түгээмэл, жам ёсны зүйл гэсэн философичдын болон эрх зүйчдийн үндэслэлийг сөрж буй юм. Зөвхөн түүний гэлтгүй антропологийн ухааны үзлээр бол соёл харилцан адилгүй өөр өөр байдаг тул хүний эрх зэрэг Барууны философи, сэтгэлгээний уламжлалаас үүдсэн ойлголт нь тэр бүр дэлхий дахины бусад соёлын онцлог, өвөрмөц байдалтай таарахгүй байх талтайг сануулж буй хэрэг ажээ. Тиймээс хүний эрх түгээмэл, жам ёсны зүйл гэж хүчлэн соёлын ялгаатай, харьцангуй мөн чанарыг бүдгэрүүлэх ёсгүй гэдгийг судалгаагаараа сануулсан байна.

Сингапурын соёл, хүний харилцааны жишээгээр судлаач Тай (1996) Барууны хэв маяг, философиор тайлбарлагдсан хүний эрхийн ойлголт нь тус улс шиг Азийн соёлын уламжлал, Барууны колоничлолын өвтэй нь холилдсон нийгэмд бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаад дурджээ. Сингапур хүний эрхийн өөрийн соёлын үүднээс тайлбарлах санал санаачилга гаргаж байгаа удаан жил тогтсон улс төрийнх нь соёлтой ч давхар холбогдож байгааг дурдсан байна. Мөн судлаач тус улсын Азийн соёл, итгэл үнэмшил дээр суурилсан ойлголтын үүднээс хүний эрхийг харж болох юм биш үү гэсэн нэгэн тод жишээ гэж мэтгэжээ.

Райлэс (2006) өөрийн судалгаандаа антропологийн болон эрх зүйл судалгаа хоёр хүний эрх, соёл гэх хоёр ойлголтын тухай судлахдаа өөр өөр өнцгөөс асуудал ханддагийг тайлбарлажээ. Антропологичид хуульчдыг хүний эрх гэсэн бүхнийг дарангуйлах болсон шидэт үгийн ард бүхнийг багтаах, тайлбарлах гэж хичээдгийг шүүмжилдэг. Харин хууль, эрх зүйн судлаачид антропологийг илүү эхээр хүний эрхийг ярьдаг болохыг соёлын харьцангуй байдал гэдэг хандлагаа багасгахыг хүсдэг гэнэ.

Антропологич Кован (2001) Соёл ба эрх хэмээх өгүүлэлдээ соёл, эрх хоёрыг судалсан судалгааны дөрвөн өөр хандлагыг тайлбарласан байна. Түүнийхээр нэгт, соёл, эрх хоёр эсрэгцэх үндэс нь газар газрын соёл өөр өөр өнгө төрхтэй байхад эрхийн тухай ярьж буй судлаачид түүнийг хаана ч адил түгээмэл шинжтэй гэж үздэг явдал гэнэ. Харин хоёр дахь шалтгаан нь эрхээс соёл руу гэж орчуулж болмоор ойлголт буюу ноёрхох бүлгээсээ өөр соёлтой жижиг бүлгүүд улс төрийн шаардлага тавих үед илэрдэг үзэгдэл гэнэ. Энэ шалтгааны хүрээнд АНУ-гийн уугуул иргэд өөрийн соёлыг хүлээн зөвшөөрүүлэхийн тул эрх гэх ойлголтыг ашиглаж байжээ. Гуравт, эрх бол соёл гэж үзэж хандлага гэнэ. Энэ хандлагаар бол хууль нь соёлын нэг хэсэг, тиймээс хуулийн олон чухал ойлголтын нэг эрх, хүний эрх нь соёлыг нэгэн хэсэг бол антропологийн нэгэн судлагдахуун болох бүрэн үндэстэй гэж үздэг хэсэг судлаач энэ ангилалд багтана гэсэн үг. Харин хамгийн сүүлийн хандлага нь соёлоор дамжуулан эрхийг задлан шинжлэх тухай ажээ. Уг ёсоор бол аливаа эрхийн асуудлыг судлахад соёлын үүрэг оролцоо ихийг хүлээн зөвшөөрч ашиглах хэрэгтэйг сануулж буй ажээ.

Судлаач Кукаташ (1992) Ер нь соёлын эрх гэж байдаг уу? гэсэн нэртэй өгүүлэлдээ соёл гэдэг нэршил анхнаасаа л хэсэг бүлгийг нийтлэг үнэн зүйл, шинж чанарыг илэрхийлж байсныг дурджээ. Тухайлбал Америк, Австрали тивийн уугуул иргэдийн тухай ярихад энэ соёл гэх нэршил заавал хэрэглэгддэг. Гэтэл өнөө цагийн нийгэм соёл гэхээсээ илүү либерал үнэт зүйлээ дагаар хувь хүн, хувь бодгалийн үнэ цэнэ, эрхийг чухалчилдаг болсон. Тиймээс хэсэг бүлэг нийтлэгийн мөн чанарыг илэрхийлдэг соёлын эрх гэх ойлголт хэрэглэх нь тэр бүр оновчтой биш байж болох биш үү гэсэн аргумент дэвшүүлсэн байна.

Соёлын эрхийг ангилахуй хэмээн судалгааны өгүүлэлдээ Леви (1997) соёл эрх гэх ойлголтыг нэг мөр тодорхойлж, нэг хүрээ царанд багтаах хэцүүг онцолсон байна. Тиймээс ангилж, ялган илүү цэгцтэй болгох боломж бийг дурджээ. Ингээд тэрээр хэд хэдэн ангилал дурдаж, тохирох жишээгээр тайлбарлажээ. 1-р ангилал бол Хуулиас ямар нэгэн зүйл хүсэж буй хэсэг. Жишээ нь, ангийн хууль, мотоцикл унахдаа дуулга зүүхийг хуульчлах гэх мэт. 2-т, Олонх хийдэггүй зүйлийг хүсэх, жишээ нь, олон хэлний бодлого, угсаатны холбоо байгуулахыг дэмжих зэрэг. 3-т, угсаатны бүлэг өөрийгөө удирдахад чиглэсэн буюу үндэсний цөөнх улс төрийн эрх олон авах хүсэх зэргийг хэлж байна. 4-т, өөрийн соёлыг бусад соёлоос хамгаалах чиглэлтэй буюу америкийн уугуул

иргэд, англи хэлийг хориглох, шашны цөөнх зэрэг. 5-т, бүлэг дотогшоо чиглэсэн хэв маяг буюу бүлэг дотроо гэрлэхийг шаардах гэх мэт. 6-т уламжлалт хууль журмыг сэргээхэд чиглэсэн буюу уугуул иргэдийн газрын эрхийг сэргээх, уламжлалт заншлыг хуулийг чухалчлах санаачилга зэрэг. 7-т, цөөнхийн улс төрийн эрх, төлөөллийг чухалчлах буюу уугуул иргэд, африк-америкчууд сонгуульд санал өгдөг болох асуудлыг хөндсөн. 8-т, бэлгэдлийн шаардлага буву олон янзын бүлгийн итгэл үнэмшил, оршихуйг хүндэтгэх, нийтийн амралтын өдөр, бодлого зэрэгт тусгах зэргийг шаардахыг хэлж буй ажээ. Ингээд тус судлаач энэхүү 8-н ангиллаа цааш дэлгэрүүлэн тайлбарлажээ.

Люри (1993) Соёлын эрх нэртэй номдоо соёлын эрх хэмээх ойлголт нь орчин үеийн соёлын олон хэв маягийг шинэлэг, өөр өнцгөөс тайлбарлахын зэрэгцээ социологи, соёл судлалын салбар ухааны аль алиных нь хэрэгтэй, үр дүнтэй, чухал гэсэн хандлагыг давхар илэрхийлж байна. Зохиогчийн бичсэнээр уг бүтээлийн гол онол, мэтгэлцээн өрнүүлж буй аргын эх сурвалж, гарал үүсэл нь соёл судлаач Волтер Бенжамины "механик нөхөн үржихүйн" (mechanic reproduction) үр нөлөөний тухай санаа бөгөөд зохиогч тэрхүү санааг цааш хөгжүүлж, жинхэнэ байх, хуулбарлах, дуурайлган хийсэн урлагийн ялгаа зөрөө багасаж буй постмодерн соёл дахь "эх" ба "жинхэнэ байдал" гэсэн ойлголтыг судалжээ. Бодит болон зохиомол зүйлийн хоорондох хил хязгаарыг бүдгэрсэн орчин цагийн урлаг нь Луригийн үзэж буйгаар зохиогчийн эрх, өвөрмөц байдал зэрэг соёлын олон эрхийг барааны тэмдэг, брэнд, загварчлал зэргээр тодорхойлж болох төдийгүй харьцуулж судлан эрдэм шинжилгээний задлан шинжилгээ хийж болох аж. Тэрээр хэвлэх, өргөн нэвтрүүлэг, мэдээллийн технологи гэсэн гурван томоохон соёлын технологийн талаар товч бөгөөд хүлээн зөвшөөрөгдөхүйц түүхийг бидэнд танилцуулж, орчин үеийн соёлын салбарын судалгааг хийжээ. Мөн түүний бүтээл соёлын нөхөн үржихүйн үйл явц дахь "эмэгтэйчүүд" гэсэн ангиллын ач холбогдлыг судалж, энэхүү өөрчлөлтийн жөндөр судлалын үүднээс судалсан байна.

Судлаач Виесстер (2011) Уугуул иргэдийн соёлын эрх судалгааны өгүүлэлдээ Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь соёлын болоод нийгмийн салбар нэгэн төрлийн дэглэм болон тогтож, "дарангуйлах" буюу бүхнийг ноёрхож байгааг авч үзжээ. Өөрөөр хэлбэл бүхий л зүйл хүний эрхийн хэмжүүрээр хандах, тэрхүү ойлголтыг чухалчлан үзэх хандлага ноёрхох болжээ гэсэн үг. Тэрээр энэхүү ноёрхох ойлголтыг өөр нэгэн сонирхолтой ойлголт болох уугуул иргэд

гэсэнтэй холбон үзсэн байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглал түгэн дэлгэрэхийн зэрэгцээ Уугуул иргэдийн эрх гэсэн ойлголт ч дэлхий дахинаа газар авч, тунхаг хүртэл батлагдсан байна. Энэ мэт амжилт бүтээл гэж болох зүйлийн хажуугаар тодорхой бэрхшээл саад байгааг мөн тоочин өгүүлжээ. Тэрхүү саад тотгорт батлагдсан тунхаг, баримт бичиг бодит байдалд хэрэгжихдээ тэр бүх санаад хүрэхгүй байх, хувийн болон бүлгийн эрхийг салгаж үзэх болсон уугуул иргэдэд сөргөөр нөлөөлөөд эхэлсэн тухай, уугуул иргэдийн эрхийг олон янзаар ойлгож, заримдаа сөрөг чиглэлд ч явж буйг сануулжээ.

Бэдэрин, Роберт нар 2007 онд эмхэтгэсэн Эдийн засаг, нийгэм, соёлын эрх хэрэгжих шатандаа хэмээн номдоо тус пакт батлагдсанаас хойш дэлхийн ихэнх улс орон уг баримт бичгийг дагаж буй ч бодит хэрэгжилтэд ямар бэрхшээл асуудал тулгарч буйг хэд хэдэн жишээгээр дэлгэрүүлэн тайлбарласан байна. 150 гаруй улс даган мөрдөж буй уг пакт тус эрхийн талаарх олон үр нөлөө, тусгалаа дэлхийн дахинд түгээсэн байна. Жишээ нь, хүний эрхийн сургалт, магистрын хөтөлбөр, хурал цуглаан гэх мэт хүний эрхийн төлөөх яриа хэлэлцүүлэг улам бүр дэлгэрч буй ажээ. Гэвч хүний болоод бүтцийн хүчин зүйлээс шалтгаалан уг эрхийг хамгаалах ёстой институтууд нэгэн ижил асуудал өөр өөр хариу үйлдэл үзүүлэх, хүний эрхийн тухай ойлголт нийгмийн бүхий л сэдэвт нэвчин орох зэрэг сонирхолтой үзэгдэл ажиглагдах болжээ. Мөн уг эрхийн хэрэгжилт бүс нутаг, тив тивийн уламжлалт хууль эрх зүйн тогтолцоо, шийдвэр гаргах мехнизмаас болж ялгаатай байдлаар хэрэгждэг тухай сонирхолтой жишээнүүдийг ч дурдсан байна. Гэвч дэлхий нийтийн олон бэрхшээл хүндрэлийг даван энэ төрлийн эрх нь хэрэгжсээр байгаа нь хүн төрөлхтний нийтийн ололт амжил болох ажээ. Энэ бүх ололт амжилтдаа сэтгэл ханалгүй олон улсын байгууллага, төр засаг үргэлжлүүлэх эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжилтийг дэмжихийн ач холбогдлыг онцолжээ.

Дээр дурдсан антропологийн үүднээс соёлын эрхийн судалсан судалгаа нь зөвхөн эрдэм шинжилгээний бус давхар хэрэглээний мэдлэг, хэлэлцүүлэг бүтээж, бидний ярьж буй асуудалд мэргэжлийн болоод сонирхогч талын анхаарлыг татаж буй нь сайн хэрэг юм. Аливаа асуудлыг талаар тодорхой хэмжээнд яриа мэтгэлцээн өрнөж, анхаарлын төвд орвол бүтээлч мэтгэлцээн, үр дүнтэй шийдэлд хөтлөх нь дамжиггүй. Соёлын эрхийн тухай дээрх судалгаанууд нь өмнө нь манай улсын эрдэм шинжилгээ, судалгааны ертөнцөд төдий л танил бус байсан тул энэ тайлангаар дамжуулан уг сэдвийг сонирхдог олон хүний

мэдэх, таних хүслийг өдөөх биз. Нэг талаар уг тайлангийн зорилго ч хүмүүсийг энэ асуудалд анхаарлаа хандуулахыг зоригжуулж буй билээ.

4. Монгол Улсын эрх зүйн баримт бичигт соёлын эрхийн ойлголт туссан байдал

4.1. Соёлын эрхтэй холбогдох эрх зүйн баримт бичиг

Монгол Улс 1992 онд Шинэ үндсэн хуулиа батлахдаа хүний эрхийн асуудалтай холбоотой бие даасан хэсэг тусгайлан баталсан нь 16 дугаар зүйлийн 18 заалтууд юм. Уг хэсгийн агуулга нь өмнө дурдсан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалаас санаа авсан, зарим тохиолдолд ойлголт, үг, үсгийг шууд хуулан авсан байдгийг онцлууштай. Үүнийг харахад Монгол Улс хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлстэй, эн зэрэгцэн алхана гэдгээ дам батлах гэсэн мэт сэтгэгдэл төрнө. Монгол Улсын Үндсэн Хуульд "Монголын ард түмэн бид: -улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж; хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж; **-төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж;** -хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж; -эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна" хэмээгээд цааш **Долоодугаар зүйлд** "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна" **Наймдугаар зүйлд** "1. Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн. 2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө" гэсэн нь бидний ярьж буй соёлын эрхтэй шууд холбогдох, хуулийн үндсэн заалт болж байна. Мөн Үндсэн Хуулийн хүний эрхтэй холбоотой бие даасан хэсэг болох **Арван зургаадугаар зүйлд** "Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: ... 8/соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална; ... 11/улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр

бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж илүү нарийвчлан зааж өгсөн байна. Үндсэн Хуулийн дээрх заалт нь манай улсад дахь хүний эрхийг холбогдолтой бусад хууль, эрх зүйн баримт бичгийн үндэс болдог билээ.

Үндсэн хуулиа дагалдан гарсан салбар хуулиудад соёлын эрхтэй холбоотой асуудал үүсэх, тус эрх зөрчигдөх үед ямар арга хэмжээ авах талаар нарийвчлан тусгасан байдгийг дор өгүүлье. **Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл. Хулгайлах** ангилалд: "2.2. түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж ... үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ." **18.4 дүгээр зүйл. Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчийн эрхийг зөрчих** хэсэгт: "1. Патентаар хамгаалагдсан бүтээгдэхүүнийг, эсхүл патентаар хамгаалагдсан аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг патент эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэсэн, зах зээлд нийлүүлсэн, импортолсон, худалдах санал гаргасан, худалдсан, хэрэглэсэн, эсхүл эдгээр зорилгоор хадгалсан, патентаар хамгаалсан аргыг хэрэглэсний улмаас патент эзэмшигчид бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

"2. Энэ гэмт хэргийг: 2.1. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн; 2.2. байнга тогтвортой үйлдсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" зэргээр заажээ.

Мөн хуулийн **18.5 дугаар зүйл. Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх** хэсэгт: "3. Энэ гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл

хугацаагаар хорих ял шийтгэнэ." Үргэлжлүүлээд **18.17 дугаар зүйл.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих хэсэгт:** "1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчиж бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, худалдсан, түгээсэн, улсын хилээр нэвтрүүлсний улмаас зохиогч, эрх эзэмшигчид их хэмжээний хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.байнга тогтвортой үйлдсэн; 2.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" зэргээр гэмт хэргийн зэргээс шалтгаалж оногдох ял зэмийг тогтоож өгчээ.

Мөн тус хуулийн 25.1 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах; 25.2 дугаар зүйл. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах; 25.3 дугаар зүйл. Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх; 25.4 дүгээр зүйл. Хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийх; 25.5 дугаар зүйл. Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах; 25.6 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх; 25.7 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах зэргээр соёл, түүхийн дурсгал, соёлын өв, соёлын эрхийг зөрчилд зохион шийтгэл оноох харьцангуй боловсронгуй хуулийн зохицуулалтыг дэлгэрэнгүй дурдсан байна.

Соёлын эрхийн эсрэг байж мэдэх хэрэг, асуудал бэрхшээлийг дан ганц Эрүүгийн хуулиар зохицуулах боломжгүй байдаг. Тиймээс **Зөрчлийн тухай хуульд** яригдаж буй сэдэвтэй холбоотой асуудлыг хэрхэн зохицуулсныг харцгаая. Тус хуулийн **7.10 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хууль зөрчих хэсэгт:** "1. Газрын хэвлийг дур мэдэн ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 4. Газрын хэвлийг: 4.2. ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй; 4.3. ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт

зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй; 4.4. ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" хэмээн заажээ. Мөн **8.3 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн тухай хууль зөрчих; 8.4 дүгээр зүйл. Патентын тухай хууль зөрчих; 8.5 дугаар зүйл. Барааны тэмдэг эзэмшигчийн эрх, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих** зэрэг хэсэгт тухайн тухайн зөрчлийг тодорхойлолт, шийтгэлийг тусган өгчээ.

Тус хуулийн дараагийн нэгэн бүлэг болох Соёлын өвийн тухай **9.6 дугаар зүйл. Соёлын тухай хууль зөрчих; 9.7 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих** хэсгүүдэд соёл болоод соёлын өвтэй холбоотой хэрэг зөрчлийг нямбай тодорхойлон, зохин шийтгэлийг ширхэгчлэн дурдсан нь энэ талын хууль зүйн зохицуулалт хангалттай гэж үнэлэх түвшинд байгааг харуулж байна.

Соёл, соёлын эрхийн нэгэн чухал хэсэг болох шашин, шүтлэгийн тухай агуулгыг манай улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулж өгчээ. Тухайлбал тус хуулийн **4 дүгээр зүйл.Төр, сүм хийдийн харилцааны үндэс** хэсэгт "1. Монгол Улс дахь төр, сүм хийдийн харилцаа төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх зарчимд үндэслэнэ. 2. Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй." гэсэн байна. Харин **8 дугаар зүйл. Шашны сургалт** хэсэгт "2. Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно. Энэ заалт нь шашны соёл, мэдлэг ухааны өв уламжлалын тухай шинжлэх ухааны сургалтад үл хамаарна." хэмээн тодорхой заасан нь буй.

Монголчуудын соёлын тухай хэлэлцэхэд ихэвчлэн нүүдлийн соёл, мал аж ахуйн хэвшлийн тухай яриад байдаг тал бий. Гэвч монголчуудын соёл хот, орон нутаг гэсэн ялгамжгүйгээр өдөр тутамдаа дэлгэрч, өрнөж байгаа **хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл. Хот, тосгоны аж ахуй** хэсэгт: "Хот, тосгоны аж ахуй нь оршин суугчдын нийгэм, эдийн засаг, ахуй, соёлын хэрэгцээг хангахтай холбогдсон үйлдвэр, үйлчилгээний газар, орон сууц, зам, тээвэр, холбоо, дулаан, усан хангамж, цэвэрлэх байгууламж болон хот нийтийн

аж ахуй зэргээс тус тус бүрдэнэ." гэсэн тодорхойлолт нь зөвхөн аж ахуйн тухай бус соёлын нэгэн бүрэлдэхүүний тухай давхар ярьж байна. Тиймээс тус хуулийн **21 дүгээр зүйл. Оршин суугчдын нийгмийн хамгаалалт болон ахуйн соёлын хэрэгцээг хангах талаарх хот, тосгоны захирагчийн бүрэн эрх** хэсэгт: "2. Боловсрол, соёл, эрүүлийг хамгаалах, нийгэм хангамж, биеийн тамир, спортын байгууллагаас үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлнэ... 5. Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалж, тэдгээрийн ашиглалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна." зэрэг зохицуулалт бий.

Дээр дурдсан соёлын эрхтэй холбогдож болохуйц зөрчил гэж юу байж боломжтойгоос өгсүүлэн түүнээс сэргийлэх, зөрчигдсэн нь тогтоогдвол оноох шийтгэл зэргээс гадна шагнал урамшууллын тухай дурдахгүй өнгөрч болохгүй. 2018 онд Монгол Улсын Засгийн Газар **Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам** баталсан нь зөвхөн соёлын биет бус өвд хамаарах бус бидний хэлэлцэж буй сэдэвтэй ч давхар холбогдох ач холбогдолтой болжээ. Тус журмын **Нийтлэг үндэслэлээр бол:** "Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчийг тодруулж, мөнгөн шагнал олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна" гэнэ. Улмаар **Шагналд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэхдээ;** "2.1.1. үндэсний болон олон улсын хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан, тэмцээнд амжилт гаргасан; 2.1.2. соёлын биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дотоод, гадаадад зохион байгуулагдсан арга хэмжээнд идэвхтэй оролцсон; 2.1.3. өөрийн санаачилгаар соёлын биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дотоод, гадаадад арга хэмжээ зохион байгуулсан; 2.1.4. соёлын биет бус өвийг хамгаалах, хөгжүүлэх үйл хэрэгт идэвх, санаачилгатай оролцсон" зэрэг шалгуур гаргажээ.

Энэ мэтчилэн дэлхийн бусад улсын адил манай улсад соёлын эрхийн талаарх хууль эрх зүйн зохицуулалт боломжийн түвшинд байгаа яг эрх зөрчигдсэн үед авах арга хэмжээ хувь хүний болоод байгууллагын зүгээр гарах субъектив нөлөөнд орохгүй гэх баталгаа байхгүй юм. Нийтийн дунд тархсан ойлголтоор бол манай улсад аливаа асуудлын талаар хууль, эрх зүйн зохицуулалт хангалттай ч эцсийн шийтгэл, хариуцлага дээр ихэнх зүйл гацдаг явдал бий билээ. Хэрэв энэ хэлэлцүүлгийг бодит байдал гэж үзвэл эргээд тэр

бүхэн нь нэгэн төрлийн соёлын эрхийн зөрчил, маргаан хөтлөх үндэс болж буй юм.

4.2. Соёлын эрхийн тухай түгээмэл дурдагддаг кэйс

Манай улсад соёлын эрхтэй шууд холбоотой хийгдсэн судалгаа хомс байна. Монголчууд шиг соёл уламжлал, өв, түүхдээ хүндэтгэлтэй ханддаг ард түмний хувьд энэ талын судалгаа хомс байгаа нь нэг талаар соёлын эрх гэх ойлголт шинэ тутам байгаатай холбоотой болов уу. Гэвч энэ хэсэгт тус судалгааг эхлүүлэхийн өмнө Хүний эрхийн үндэсний комиссын судалгааны багтай уулзаж, ярилцах үед хөндөгдсөн соёлын эрхтэй холбогдож болохуйц хэд хэдэн үзэгдэл, кэйсийн талаар тухайлан судалснаа тоймлон бичих юм.

НҮБ-ийн Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай хорооноос 2014 онд Монгол Улсын Засгийн газрын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Пактын хэрэгжилтийн талаарх дөрөвдүгээр илтгэлийг хэлэлцүүлсэн талаарх дүгнэлтдээ соёлын эрх гэсэн тусгай хэсэг гаргаж "Хороо нь хөрөнгө мөнгөний хомсдлын улмаас хэрэгжилт нь хангалтгүй байгаа Урлаг соёлын талаарх үндэсний бодлогын хэрэгжилтэд анхаарлаа хандуулж байна. Хэдийгээр энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч соёлын өвийг хадгалах, хамгаалах асуудалд мөн анхаарлаа хандуулж байна" гээд цаашлаад дараах зөвлөмжийг өгчээ. Тэдгээр нь: "Урлаг соёлын асуудлаарх Үндэсний бодлогын хэрэгжилтийг сайжруулахад шаардлагатай хөрөнгө мөнгийг зарцуулах; 2014 оны Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хяналтыг сайжруулах замаар соёлын өвийн хадгалалт, хамгаалалтад оруулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, энэ чиглэлээрх хүчин чармайлтаа сайжруулах" гэсэн байна. Өөрөөр хэлбэл тус зөвлөл, хороо Монгол Улс дахь соёлын эрхийн талаар анхаарах ёстой салбар хүрээг дээрх маягаар тодорхойлсон гэсэн үг.

Мөн тус дүгнэлтийн Боловсрол гэсэн хэсэгт: сургууль завсардалтыг багасгах, сургуулийн хүрэлцээг нэмэхийг зөвлөсөн бол Малчдын эрх гэсэн тусгайлсан хэсэгтээ: уул уурхайгаас болж малчдын ахуй амьдрал, малын бэлчээр усанд учрах аюулыг урьдчилан тооцох, хууль эрх зүйн ойлголтыг нэмэх, зохих нөхөн төлбөр зэргийг өгөхийг сануулж байжээ. Энэ хэсгийн санал зөвлөмж одоо ч үнэ цэнээ алдаагүй буюу дээрх асуудал байсаар байгааг биш дэд бүтцийн болон уул уурхайн төслийн талаар санал, сэтгэгдлээ хэлсэн орон нутгийнхан тэр

бүр сайн нэр зүүхгүй байгаагаас харж болно. Өдөр тутмын мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр өөрсдийн бэлчээр, нутагт эхлэх гэж буй ямар нэгэн төслийн үр өгөөж, үр нөлөөний тухай санал хэлж буй малчид "шантаажчин, улс орны хөгжлөөс улдан чангаагч" гэх зэрэг хоч нэр зүүхээс гадна "тэдний хэлж ярьж буйг анхаарах хэрэггүй, төслөө даруй эхлүүл" зэрэг яриа хэлэлцүүлэг илт давамгайл өрнөх боллоо. Гэтэл бодит байдал дээр орон нутгийн иргэд тэр дундаа малчдын дуу хоолой шийдвэр гаргах түвшинд хүрдэггүй, нөхөн төлбөрийн асуудал ч анх хэлэлцэж тохирсны дагуу байдаггүй гэх мэт сөрөг жишээ баримтыг судлаачид дэлгэсээр байна (жишээ нь, Sternberg, Ahearn & McConnell 2020; Ahearn & Namsrai 2021-ийг үзнэ үү).

Дээрх зөвлөмж, дүгнэлтийн дараа НҮБ-ийн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо 2019 онд гаргасан ижил зорилготой дүгнэлт, зөвлөмждөө өнөөх соёлын эрхийн тухай хэсгийн дахин хөндөж "Соёлын өвийг хамгаалах хууль, бодлогын хэрэгжилт, түүний дотор Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014 он), Соёл урлагийн талаарх бодлогын үр нөлөөллийн талаар мэдээлэл өгнө үү" гэсэн байдаг. Энэхүү хоёр дүгнэлт, зөвлөмж нь олон улсын байгууллага монгол дахь соёлын эрхийг нөхцөл байдлыг хэрхэн харж, ойлгож, дүгнэж байгааг харуулж буй давуу талтай юм.

Хүний эрхийн үндэсний комиссын жил тутмын "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлд" соёлын эрхийн асуудлыг хөндсөн судалгаа, кэйс дурдагдсан бий. Тухайлбал, үндэсний цөөнхийн эрхийн төлөв, өнөөгийн нөхцөл байдлын тухай, хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрх нөхцөл байдлын талаар (ХЭҮК 2004; 2010; 2017), нийгэмд маргаан дагуулсан асуудал болох хурдан морь унаач хүүхдүүдийн эрхийн асуудал (ХҮЭК 2013) зэргийг дурдаж болно.

Монгол Улсын хэмжээнд манай уламжлал соёл ямар нэгэн байдлаар хүний эрхийг зөрчилд хөтөлж буйг төдийгүй Монгол Улсын иргэн соёлынхоо үр шимийг хүртэхэд тулгарч буй бэрхшээл зэргийг судалсан судалгаа хомс юм. Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлд дурдсан үндэсний цөөнхийн эрх, морь унаач хүүхдийн эрх зэрэг нь бүрэн дүүрэн шууд соёлын эрхтэй холбогдох гэхээсээ илүү хүний эрх гэсэн ерөнхий ойлголтод багтааж үзвэл илүү учир зүйн холбоостой болохоор байна. Үүний адилаар жендерийн эрх тэгш байдлын хангахтай холбоотой ч соёлын илэрхийлэлтэй давхар холбогдож болох "Дархан бэр" тодруулах ёслол, шагнал эсвэл шагайн харваа, бөхийн барилдаанд

эмэгтэйчүүд оролцдоггүй, овоо зэрэгт эмэгтэй хүн гардаггүй зэрэг тогтсон ойлголтууд цөөнгүй байна.

Дархан бэр хэмээх шагнал ёслол нь УИХ-ын гишүүн асан, хөрөнгө чинээтэй нэгэн гэр бүлийн санаачилгаар эхэлж, улмаар хөдөө орон нутагт багагүй газар авсан соёлын бүтээл (cultural construction) болжээ. Энэ шагнал, ёслолын санаачлагч энэ санаачилгаараа хүн зоны дунд тодорхой нэр хүнд олж, нийгмийн капитал цуглуулж буй нь зайшгүй бөгөөд түүнийгээ хувийн бизнес, улс төрийн нэр хүндтэйгээ ч холбох гэж оролдож болох юм. Уламжлалт түүх соёлд эмэгтэй хүнийг хүндэтгэх тэр дундаа "цэцэн бэр", "дархан бэр" зэрэг ойлголт байсан ч өнөөгийнх шиг шагнал, ёслол болж байсан гэх баримт хомс байгаа юм. Нэг талаар хүндлэл гэдэг маш том шагнал, урам байдаг тул ёслол зохион байгуулах хэрэгцээ ч тухайн үед байгаагүй болов уу. Мэдээж эрдэм шинжилгээний үүднээс шагнал өгч, авч байгаа, авах "дуртай" байгаа хэн нэгний зөв бурууг ярихаас илүү энэ шинэхэн санаачилга ямар утга учир, нөлөө тусгалтай байгааг нь цааш сайтар судлах хэрэгтэй байна.

Өөр нэгэн сонирхолтой жишээ бол өмнө дурдсан бөхийн барилдаан болон шагайн харваанд эмэгтэй хүн оролцохгүй, овоо зэрэг тахилга тайлгын газар эмэгтэй хүн гардаггүй гэсэн яриа юм. Барууны ойлголтод тулгуурласан жендерийн ухагдахууны үүднээс энэ бүхнийг эмэгтэй хүний эрхийг боогдуулсан гэж үзэх нь нэгэнт манай улсад тогтсон байгаа хэлэлцүүлгийг идэвхгүй дагаж буй хэрэг болно. Үүний оронд уг судалгаа дээрхийг байдлын учрыг олоход анхаарвал уламжлалт түүх соёлын үүднээс нүүдэлчдийн дунд эмэгтэй хүн бөх барилдах нь байсан зүйл ажээ. Өнөө ч Казак, Киргизүүдийн дунд эмэгтэй бөхийн барилдаан бий төдийгүй монголын түүхэнд эр хүн шиг хүчтэй чадалтай, эрчүүд ч дийлдэггүй байсан бөх эмэгтэй тухай тэмдэглэл, домог яриа байдаг. Ерөнхий утгаараа алив баяр ёслол, зан үйл цэнгэгч, цэнгүүлэгч гэсэн хоёр талтай тул өнөө цагийн бөхийн барилдааныг энэ талаас нь харж тайлбарлавал илүү нуруутай хандлага гарахаар байна.

Харин шагайн харваа гэх наадаан саяхан буюу 1998 оноос Үндэсний баяр наадмын хөтөлбөрт багтсан байна. Уламжлал ёсоороо бол эр, эмгүй чөлөөт цагаараа тоглодог наадаан байгаад өнөө төрийн наадмын нэг бүрэлдэхүүн болсон нь олон маргаан дэгдэх үндэс болжээ. Энгийн наадаан байсан үед түүнийг эрэгтэй, эмэгтэй хүн тоглох нь төдий л чухал бус байснаа цол, зэрэг өгдөг, шагнал урамшуулалтай болоод ирэхээр хэсэг бүлэг хүнд эмэгтэй хүн

тэрхүү нөөцийг булаацалдаг өрсөлдөгч болж харагдсан байна. Нэгэнтээ өрсөлдөж олж авдаг тэрхүү нөөц, баялагт өрсөлдөх хүнийг тоог хасах, багасгах тусам өрсөлдөөн багасаж, тэрхүү хэсэг бүлэг хүн шагнал урамшуулалдаа хурдан хүрэх боломж үүсэх нь дамжиггүй. Энэ кэйс дээр үүсэж буй сонирхолтой зүйл бол шагайн харваа төрийн наадмын нэг хэсэг бол улам дэлгэрч, хөгжиж буй бус түүнийг өмчилсөн, хяналтдаа байлгах гэдэг хэсэг хүний сонирхол хүсэл л дэлгэрч, хөгжсөн сонин прадокс ажиглагдаж буй юм. Үнэхээр л уламжлал үгүй гэхэд 1921 оны хувьсгалаас өмнөх баримт болон судлаачдын судалгаагаар эмэгтэйчүүд чөлөөтэй шагай харвадаг байжээ. Харин өнгөрсөн хугацаанд нийгэм өрнөсөн хэлэлцүүлгийн агуудга, контекстийг судалж үзвэл шагайн харвааг хүний эрхийн зөрчилд ч хөтөлж мэдэх байдалд аваачиж буй хэсэг эрэгтэй шагай харваачийн үйлдэл болох нь харагдаж буй тул тэр хэсгийн үйлдлийг зохицуулах боломж бүрэн байгаа гэж үзлээ.

Хурдан морь унаач хүүхдийн эрхийн зөрчил, бэртэл гэмтэл, амь насны эрсдэл бидний зайлшгүй анхаарах ёстой асуудал болчихоод байна. Гэхдээ энд ялгаж салгах ёстой хоёр ойлголт байгаа нь үнэхээр монголчуудын хүүхдээр морь унуулж, уралдуулах соёл нь мөн чанараараа хүүхдийн амь насанд заналхийлдэг, "алуурчин соёл уу", аль эсвэл өнөөгийн хэлбэр, хэв маяг нь ийм болчихоод байна уу гэдэг асуудал юм. Бидэнд өмнө нь морь уралдахад хүүхдийн эрүүл мэнд, амь нас ямар байсан тухай мэдээ, дата алга тул түүхэн, уламжлал ямар байсныг баттай хэлэх боломж хомс байна. Харин сүүлийн үеийн тоо баримт олон нээлттэй байгаа энэ талын маргаан мэтгэлцээн өрнүүлэх хангалттай дата болж буй юм. Өөрөөр хэлбэл өнөө цагт хүүхэд мориноос унаж буй тов тодорхой анхаарах ёстой асуудал мөн гэсэн үг. Соёлын салбарын судлаач, мэргэжилтэн нартай уулзаж, хүүхэд мориноос унаад буйн шалтгааны сонирхож үзэхэд үндсэн гурван зүйлийг дуу нэгтэй хэлж байна. Тэдгээр нь: нэгт, ахуй амьдралын өөрчлөлтөөс болж морь сайн унадаг хүүхдийн тоо ховордсон; хоёрт, морины уралдааны бооцоо шагнал, цол зэрэг, нэр алдар зэрэг олон зүйлийн капитал, нөөц баялаг санал болгох болсон нь ихэссэн тул уралдааны тоо урьд өмнө байгаагүйгээр нэмэгдэж, морь унах хүүхдийг эрэлтийг нэмснээр морь сайн унаж чадахгүй, сураагүй хүүхдийг ч гэсэн мордуулах нөхцөлд хүргэсэн гэнэ. Магадгүй энэ шалтгаан хүний эрхийн байгууллагуудын түлхүү ярьдаг амьдралын боломж муу, хагас өнчин зэрэг хүүхэд цалин хөлсгүй морь унадаг, бэртэж гэмтэж, эрх нь зөрчигддөг гэсэн хэлэлцүүлгийн үндсэн шалтгаан болов уу. Харин гуравдугаарт,

томоохон уралдаан морь гаргахдаа 100-150 метр урт ногоон торны цаана морьдоо эгнүүлэн гаргадаг болсноор шахцалдаан үүсгэх, хүүхдүүд нэгнээ дэгээдэх зэрэг үндсэн нөхцөл болдог гэсэн шалтгаан юм. Ярилцсан судлаачид маань ч мориноос унаж буй хүүхдийн олонх нь гарааны зурхай дээр унаад байгааг онцолж байв. Ингэж үзвэл уг асуудлыг үндсэн хоёр шалтгаан нь зохион байгуулалт, төрийн оролцоотой холбоотой байгаа нь харагдаж байна. Тиймээс энэхүү зохион байгуулалт гэдэг зүйлд илүү анхаарч чадвар энэ асуудлыг шийдэл олдох болов уу.

Дараагийн анхаарах соёлын эрхийн асуудал оршуулгын зан үйлтэй холбоотой үүсэж болохуйц байна. Монголын криминологичдын холбооны захиалан хийлгэсэн "Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн эрх зүйн антропологийн судалгаа" төслийн ажлын хээрийн судалгааны үед Баян-Өлгий аймгийн зарим сумдад казак иргэдийн оршуулгын зан үйлтэй холбоотой асуудал, бэрхшээл үүсэж болохуйц байгааг судлаачид тэмдэглэжээ. Учир нь сүүлийн жилүүдэд казак түмэн уламжлалт гэх аргаар оршуулгын зан үйлээ үйлдэх болсон байна. Уг арга нь гадна талаасаа харагдах байдал нь модоор хийсэн байшин-бунхан маягтай бөгөөд зарим газар энэхүү оршуулгын газар нь багахан тосгон мэт харагдах болж, зарим казак бус түмний малын бэлчээр зэрэгтэй ойрхон байрлах болжээ. Соёл уламжлалын үүднээс өөр соёл, заншлыг хүндэтгэж үзэх хэрэгтэй ч дээр дурдсан судалгааны хээрийн шинжилгээний үеэр судлаачид зарим дургүйцэл, талцал, үл ойлголцлын талаарх жишээ баримт тэмдэглэсэн байна.

Энэ хэсэгт дурдахгүй өнгөрч болохгүй өөр нэг асуудал бол монголчуудын уламжлалт аж ахуйн хэвшил болох мал аж ахуй, бэлчээртэй холбоотой соёлын эрхийн ойлголт хөндөгдөж болох эсэх асуудал юм. Малын тоо толгой урьд өмнө байгаагүй их хэмжээнд хүрч, олон малтай малчин, бага малтай нэгнээ хүч түрэн бэлчээр, уснаас нь шахах зэргээр тэгш бус байдлыг нэмэгдүүлэх шинж тэмдэг ихсэж байгааг судлаачид дурдах боллоо (И.Бямбабаатар, Г.Цогзолмаа 2021). Энэ байдал дээр нэмэгдэн уур амьсгалын өөрчлөлт, ган гачиг, хуурайшил, зуд турхан, цас мөс, үер ус зэрэг байгаль орчны хүчин зүйл малчдын амьдралын чанарт шууд болон дам маягаар нөлөөлөх болжээ. Нэгэнт нөхцөл байдал хэцүү, бэрх болж ирэх үед хязгаарлагдмал нөөц баялаг болох бэлчээр, ус, мод ургамалаа нутгийнхан өөртөө л өмчлөх хүсэлтэй болж, өөр нутаг уснаас нүүж ирсэн малчдыг шахаж хавчих явдал нэмэгдээд байгаа гэнэ. "Хүний эрхийн

үүднээс эдгээр тохиолдлуудыг авч үзвэл, малчдын түр буюу байнга оршин суух газраа сонгох эрх, соёлын эрх, аюулгүй орчинд амьдрах зэрэг олон эрхийг ноцтой зөрчиж байна. Энэ нь малчид бэлчээр ашиглалтын уламжлалт соёлоо үргэлжлүүлэх эрхийг зөрчиж, бэлчээрийг хувааж, нэгдэл (социализмын үеэс эхэлсэн), сумын захиргаанд эзэмшүүлж, нүүдлийг хязгаарлах болсонтой холбоотой (И.Бямбабаатар, Г.Цогзолмаа 2021) гэнэ. Энэ бүх бэрхшээл дээр нэмэгдэн олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр хийгээд төр засгийн, нийгмийн зүгээс малчдыг "бүдүүлэг, хоцрогдсон технологитой, дэвшиж, хөгжиж дээшлэх ёстой", "суурин амьдрал, эрчимсэн аж ахуйд шилжин, хоцрогдмол аж ахуйгаа орхих" хэрэгтэй мэтээр байнга буруутгах нь түвэгтэй байдал үүсгээд байна. Энэхүү малчид малаа замбараагүй өсгөж бэлчээрийг талхалдаг, нүүдэлчид хоцрогдсон, заавал суурьших тухай ойлголтыг өнгөрсөн зуунд (Dulam, 2017) буюу Зөвлөлтийн нөлөөтэй социализмийн үеэс эхтэй бөгөөд одоо ч утга, логикоо өөрчлөөгүй үргэлжилсээр байгаа нь харамсалтай. Төр засгийн зүгээс энэ маягаар малчдыг, мал аж ахуйг "дорд" харах нь нэгэн төрлийн соёлын эрхийн зөрчил юм. Үнэндээ хэн нэгэн өөрийн хүссэн байдлаар амьдрах, заавал нэг хүний төсөөлөл, тулгалтанд хүрч, багтаж байх албагүй тул дээрхийн мэт албан болоод албан бус тулгалтууд нь зүй ёсны үйлдэл биш юм.

5. Монгол Улс дахь соёлын эрхийн өнөөгийн байдлын кэйс

Энэ хэсэгт соёлын эрхтэй холбогдож болох асуудлыг хөндсөн урьд өмнө хийгдсэн судалгааг дурдахгүй. Мөн өмнөх хэсэг болох 4.2-т дурдсан кэйс, жишээний тухай ч багтаасангүй. Учир нь алив судалгаа гэдэг шинэ мэдлэг бүтээх, байгаа судалгаа, мэдээллийн тоо, чанарыг урагш ахиулах, байгаа тайлбар мэдлэгээс өөр хувилбар санал болгох ажил хийж байж л сая судалгаа гэдэг нэр, түвшиндээ хүрдэг. Тиймээс доор хэсэгт монголын судалгаа, эрдэм шинжилгээний ертөнцөд тэр бүр ярьдаггүй, эсвэл бага анхаарал хандуулсан соёлын асуудал, түүний соёлын эрхтэй холбогдох боломжийг судлан илрүүлснээ таван хэсэгт хуваан тайлбарлаж, үндэслэлээ бататган мэтгэж буй юм. Энгийнээр хэлбэл, өмнө дурдсан морь унаач хүүхдийн нөхцөл байдал, үндэсний цөөнхийн эх хэл дээрээ боловсрол эзэмших боломж бололцоо, эрхийн байдал, үндэсний цөөнхийн соёлын эрхийн асуудал, зарим нэг зан үйл, тоглоом наадаан дахь эмэгтэйчүүдийн оролцооны тухай зэрэг харьцангуй судлагдсан, нөхцөл байдал нь тодорсон, анхдагч мэдээлэл хэвлэгдэн гарсан сэдвийг хойшлуулан, тэр бүр дурдагддаггүй сэдвийг илүү хамруулсан бичсэн гэсэн үг. Тус тайланд зориулсан судалгааны явцад илэрч гарч ирсэн доорх таван кэйсийг онцгойлон авч үздэг нь тэдгээрийг ирээдүйд тус тусад нь судлах боломж байгаа гэдгийг давхар сануулах зорилготой юм.

5.1. Хуваалцдаг соёлын өвийн асуудал

Соёл гэдэг улс төрийн хил хязгаар, аль нэг улсын улс төрийн үзэл суртлын зааг, хүрээнд багтдаг зүйл биш юм. Жишээ нь, монголын соёл гэдэг зөвхөн Монгол Улсын иргэдийн соёл бус хөрш зэргэлдээ улс орон амьдарч буй өөр олон монголчууд тэр ч бүү хэл Дотоод Азийн бусад нүүдэлчин соёлтой ард түмний ч өв байдаг онцлогтой. Гэтэл манай улсад монголын соёл гэдгийг зөвхөн манай улсын иргэнд л хамаарч байх ёстой мэтээр сэтгэж, ойлгох нь бий. Үүний тодорхой жишээ бол Монгол Улсын албан түүх бичлэг олон монголчууд Манж Чин Улсын эрхшээлд орсон үеэс хойших түүхээ бичихдээ дэлхий даяар тархсан бусад монголчуудаа багтаадаггүй байдал юм. Түүнчлэн хөөмий, дээл, зарим нэг хөгжмийн зэмсэг зэргийг зөвхөн бид л өмчлөх ёстой мэтээр авирладаг нь

дээрхийн нэгэн тод жишээ. Гэтэл хөөмий нь Тува зэрэг бусад нүүдэлчдийнх, дээлийн олон төрөл зүйл нийт нүүдэлчдийн дунд ч гэсэн байна. Энэ байдал соёлын эрхийн асуудал бэрхшээл болох бүрэн боломжтой сэдэв болж томроод байгаа юм байна. Жишээ нь, Монгол улсын иргэн би дээрхийн мэт соёлын өвөө минийх гэж илэрхийлэх өмчлөх гэхэд бусад нүүдэлчид ард түмний нөхцөл байдлыг юу гэж тайлбарлах вэ? Эсвэл тухайн ард түмний төлөөлөл дээрх соёлын өвөө ашиглах, ашиг олох, элдэв эргэлтэд оруулах, цэнгэл жаргах соёлын эрхээ эдлэх гэвэл манай улсын иргэдийн уламжлал, соёл өвийн асуудлыг юу гэж тайлбарлах вэ гэсэн асуудал үүсэхээр байна.

Энэ сэдэвтэй уялдаад ЮНЕСКО-гийн соёлын биет бус өвийн жагсаалтад (UNESCO 2003) өвөө бүртгүүлэх дэлхий дахины уралдаанаас болж дээрх мэт хуваалцдаг, олон ард түмний дундын соёлын өвийн асуудал, түүнийтэй холбоотой соёлыг эрхийг яах вэ гэдэг маргаан дэгдээд удлаа. Үнэндээ дээр жагсаалт өөрийгөө соёлыг өвийг хамгаалж, хайрлаж байгаа гэж сурталчилдаг ч эргээд бидний ярьж буй олон асуудлыг эхлүүлээд байгаа биш үү гэсэн асуулт зүй ёсоор гарна. Ялангуяа манай улс энэ жагсаалтаа соёлын өвөө идэвхтэй бүтгүүлж буй тул яригдаж буй хуваалцдаг соёлын өвийн асуудал үүсэх нөхцөл бэлэн байгаа юм. Үнэндээ бидэнд ийм түүх байгаа аж. Судлаач Б.Цэцэнцолмон (2014) энэ талаар судалгаа хийж БНХАУ 2003 онд морин хуурыг “Монголын соёлын өмч” гэж ЮНЕСКО-д бүртгүүлэхэд, 2005 онд уртын дууг Монгол, Хятад хоёр улсын нэрээр хамтран бүртгүүлэхэд монголчууд төдий л хүчтэй эсэргүүцэж, үндсэрхэг үзэл гаргаж байгаагүй ч 2009 онд хөөмийг “Монголын дуулах урлаг: хөөмий буюу хоолойн цоор” гэсэн нэрээр бүртгүүлэхэд ихэд эсэргүүцсэн явдлыг эргэцүүлсэн байна. Магадгүй 2003, 2005 онд монголчууд тус жагсаалтын талаар ойлголт багатай байсан биз. Учир нь манай улс ЮНЕСКО-гийн биет бус соёлын өвийн хамгаалах конвенцид 2005 онд нэгдэж орсон байдаг.

Тус судлаачийн үзэж буйгаар бол хөөмийтэй холбоотой уг маргаан нь "урлагийн төрлөөр дамжуулан үндэстэн, угсаатны хил заагийг улсын хилтэй давхцуулан тогтоох хандлага олон нийтийн дунд идэвхжиж, соёлын өв хөрөнгийг эзэмших эрхийн төлөөх “өрсөлдөөн” болж хувирсан мэт” гээд тухайн үед өрнөж байсан үйл явцыг "2009 онд БНХАУ хөөмийг бүртгүүлсний дараа Монголын өдөр тутмын сонин, телевизийн сувгаар “манай зүйлс урд хөршийн нэр дээр бүртгэгдсэн”, “олон зүйлээ харийнхны олз болгож”, “хятадаар овоглосон”, “харьд алдагдсан”, “хулгайд алдсан” гэх мэтээр бичиж ярих болсон. Үүний зэрэгцээ

мэдээллийн хэрэгслийнхэн буруутныг олж тогтоох гэж хичээж байлаа. Энэ явдалд хэд хэдэн хүн буруутгагдаж байв. Үүнд: Монголд авдаг цалингаасаа 10 дахин илүү төлбөрөөр Өвөрмонголчуудад очиж хөөмий зааж өгсөн гэх Б.Одсүрэн багш; Монголын Одсүрэн багшаар заалгачихаад багшаасаа урьтаж "соёлын тээгч" болсон Өвөрмонгол шавь нар нь; Улсаас санхүүжилт авдаг хирнээ идэвхтэй ажиллаагүй Монголын хөөмийн үндэсний хороо, тэр дундаа А.Цэдэн-Иш тэргүүтэй Хөөмийн холбоо; Хятадаас түрүүлээд хөөмийг бүртгүүлж чадаагүй ЮНЕСКО-гийн Монголын үндэсний хороо (Хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Н.Уртнасан уг явдлын дараа халагдсан) зэрэг болно" (Цэцэнцолмон 2014) хэмээн тайлбарлажээ.

Дээрхээс үзэхэд бид хөрш зэргэлдээ улсад амьдарч буй олон монголчууд төдийгүй бусад нүүдэлчидтэй хуваалцдаг соёлын өвөө ашиглах, илэрхийлэх, "эдлэх, үр шимийг нь" хүртэх гэх үед тулгарч мэдэх зарим асуудал хөндөгдөж байна. Тиймээс үүсэж мэдэх энэ мэт асуудлыг урьдчилан харж, эрсдэлийг буруулах алхам, арга хэмжээгээ төлөвлөх зайлшгүй хэрэгцээ байна. Учир нь энэ мэт хуваалцдаг соёлын өв нь бидний үндэсний ижилслийг бүтээдэг, бүтээхэд нэг чухал гэж үздэг морин хуур, уртын дуу зэрэг өвүүд байгаа юм. Энэ нөхцөлд бидний бус бусадтай хуваалцдаг соёлын өв дээр суурилан боссон үндэсний ижилслийн нас, хүчин чадал, чанар ямар зэрэг байх вэ гэдэг асуулт өөрийн эрхгүй урган гарна.

5.2. Тайзны соёл уу эсвэл ахуйн соёл уу?

Социализмын болоод пост-социализмын аль ч үед Монголын төр ард иргэдээ, үндэстнийхээ соёлыг соёлтой/соёлгүй-бүдүүлэг, орчин үеийн/хоцрогдсон-феодалын, хөгжсөн/хөгжөөгүй зэргээр ангилан, ялгаж байна. Өөрөөр хэлбэл хот/хөдөө, орон сууц/гэр хороолол, "улны"/улны бус, залуу, халамж хүртэгч/ажилсаг, халамж авдаггүй зэрэг ангилал, зэрэглэл нь тодорхой хэмжээнд тухайн нийгмийн бүлгийн соёл, соёлын илэрхийлэлтэй холбогдож байдаг гэсэн үг. Судлаачдын үзэхээр БНМАУ социалист, шинэ нийгмийг бүтээн байгуулахдаа соёлтой, соёлгүй гэсэн ойлголтыг асар их ашигласан байдаг аж. Монголын уламжлал соёл феодалын, харин шинэ тутам суралцаж буй соёл орчин үеийн, Зөвлөлтийн зэрэг нэртэй байж, илүү хүндлэгдэж байжээ. Улмаар социализмын хожуу үед евро-америк төвт гэж болохуйц ойлголтын үүднээс суурин иргэншилтэй ард түмэн "соёл иргэншилтэй, соёлтой", харин суурин бус нүүдлийн

соёлтой монгол мэт ард түмэн "соёл иргэншилгүй, соёлгүй, бүдүүлэг, ураг төрлийн холбоо дээр суурилсан, төргүй" (Lattimore 1940; Barfield 1989; Khazanov 1994) нийтлэг гэсэн ойлголт түгсэн байна.

Монгол судлаач эрдэмтдийн олонх нь ч дээрх ойлголтыг нягтлан, шүүн тунгааж үзэлгүй зохиол бүтээлдээ идэвхгүйгээр давтан ашиглах болж, дээрх үзэл санаад суурилсан бодлого, дүрэм журам үргэлжлэн гарсаар байгаа нь харамсалтай. Энэ бүхний нэгэн баталгаа нь гарчигт дурдсан шиг монголчуудын соёл гэж хүний ахуй амьдралын хүрээнд буй зүйлийг хэлж байна уу аль эсвэл олон үзүүлдэг, тайзны, урлагийн болсон зүйлийг хэлж байна уу гэсэн маргаан юм. Жишээ нь, сонгодог урлаг,-хөгжим бол жинхэнэ урлаг гэх яриа түүний эсрэг талд ардын, зохиолын дуу зэрэг нь зэрэглэл доогуур мэт үнэлэмж юм. Социализмын үед ардын соёлын зүйлс нь үндэсний үзэл илэрхийлсэн гэгдэг зарим тохиолдолд улс төрийн хэрэгт ч татагдаж мэдэх нөхцөл байдалд байсан бол өнөөдөр "орчин үеийн бус, хөгжөөгүй, хоцрогдсон" гэх ангилалд багтахаар болсон байна.

Төрөөс ч соёл, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж буй нэрийн дор олон төрлийн баяр, ёслол, фестиваль зохион байгуулж, соёлын өв тээгч зэрэг шинэ нэршил зохион, шагнал урамшуулал өгөх болж, батламж, гэрчилгээ, үнэмлэх зэргийг олгох болжээ. Энэ мэт шинээр үүсэн соёлын нөөц баялаг, ашигтай зүйлийн төлөө ард иргэд ч хоорондоо тэмцэлдэх болж, "би жинхэнэ өв тээгч, тэр хуурамч" гэх мэт яриа ил цагаан гарах болжээ. Зарим шог яриагаар бол "Ховдын Чандмань сумынхан л жинхэнэ хөөмийчин бусад нь хаа нэгтэйгээс сурсан, жинхэнэ биш хүмүүс" гэх мэт ойлголт түгэх болов.

Энэ бүх үйл явцыг өнгөц харахад төр засаг соёлын өвөө хайрлан хамгаалж, түгээн дэлгэрүүлж буй мэт болов энэ соёлын бүрэн эрхт гишүүн хэн нэгэн тухайн соёлыг өвийг илэрхийлэх, эдлэх боломжийг "соёлын өв тээгч" гэх нэр зэрэг, шагнал урамшуулал зэргээрээ хязгаарлаж байгаа дүр зураг гараад байна. Нэгэнт бий болсон тэрхүү нэр хүнд, шагнал урамшуулал гэх нөөц баялаг нь хүний сонирхол, хүслийг өдөөр нь аргагүй төдийгүй (Tsetsentsolmon 2014) дам утгаараа соёлын эрхийн асуудалд хөтлөн хэмжээнд хүрчээ. Судлаач бид антропологийн хээрийн судалгаагаар орон нутгаар явах үед ч соёлын өв тээгч нарын дунд хүртэл "би жинхэнэ, тэр биш" гэх эсвэл соёлын өв тээгч гэсэн албан бичиг баримттай хүн нь өнөөх соёлын өвөө "мэддэг" нэгэн нь бус ямар нэгэн байдлаар тухайн бүртгэлт багтсан нэгэн байх ч тал ажиглагддаг.

Цаашлаад төрөөс соёлоо түгээн дэлгэрүүлэхэд хийж буй ажил тухайн соёлын өвийн "анхдагч" байдлыг хөндөн, хувиргаж, уугуул төрх байдлаас нь өөр болгож байгаа жишээ цөөнгүй байна. Үүнийг нэг үгээр тайзны соёл гэж болно. Төрөөс нэр, шагнал урамшуулал авсан соёлын өв тээгч өнөөх өвөө олонд үзүүлж, түгээх, шавь хүртэл бэлтгэх үүрэг хүлээдэг. Эндээс аль болох их хэмжээгээр соёлын өвөө олонд үзүүлнэ тэр хэрээр өнөөх өв түгэн дэлгэрч буй мэт дүр зураг гарна. Ингээд угтаа өвөл, гэр бүл, саахалтынхаа дунд хайлдаг байсан, засан номын шинжтэй гэж үздэг тууль нь хэдийд ч хайлж болдог, олон хүн цуглуулаад хайлдаг, засал номын утга холбогдол ч бага болж тайзан дээр байгаа юм. Үүний адилаар тайз-жсан, тайз-лаг болсон, үзүүлэн, үзмэр болсон соёлын өв эсвэл соёлын өв улам бүр ийм шинжтэй болж, бодит ахуй амьдралаас, хүний амьдралаас холдох нь алсдаа соёлын эрхийн асуудалд хөтлөх янзтай болоод байна.

Мөн төрөөс ч Үндэсний урлагийн дэмжих хөтөлбөр, Уртын дуу, морин хуурын үндэсний хөтөлбөр, Төрийн хан хуур, Монгол төрийн үндэсний хөгжмийн их найрал зэрэг хөтөлбөр, ойлголтыг ч батлан гаргаж, олон нийтийн дунд соёлоо улам таниулж буй гэгддэг. Гэтэл бодит байдал дээр энэ мэт бодлогын үр дүн яг эсрэгээрээ гарч соёлын бүтээл (social construction) л болж, анх зорьсон утгаасаа алсарч холдоод байгааг (Tsetsentsolmon 2015) зарим судлаач анхааруулсаар байгаа юм.

Гэтэл энэ бүх соёлын үзэгдэл, үйл явцын судлан таниулах ёстой соёл судлал зэрэг ухаан нь яг ямар ухааны дэг сургуулийг дагаж буй, ямар онол, арга зүй ашиглаж буй тодорхойгүй, бүх зүйлийн нийлмэл, холимог янзтай байна. Монгол Улсад буй соёл судлалын ухаан нь Зөвлөлт-Оросын культурлогия юм уу эсвэл англи хэлт ертөнцөд буй соёл судлалын (cultural studies) чиг баримжаатай (Мөнх-Эрдэнэ 2015) юм уу гэдэг нь одоо ч тодорхой бус, судалдаг сэдэв, судлагдахуун нь ч сайн тогтож өгөөгүй л байна.

5.3. Үндэсний хэл боломж/саад

Энэ хэсэгт үндэсний цөөнх болсон казак түмний соёлын эрхийг тухай товч өгүүлнэ. Ингэхдээ "уламжлал" болсон, өмнө нэгэнт судлагдан аль нэг байгууллагын тайланд дурдагдсан сэдэв болох тэдний угсаа гарал, хэлний асуудал эсвэл эх хэл дээрээ боловсрол олж авах эрхийг хөндөхгүй. Харин

үндэсний цөөнхийн эрхийг хангаж буй гэсэн үйлдэл нь эргээд ямар нөхцөл байдал үүсгэснийг тайлбарлах юм.

Нэн тэргүүний Монгол Улсад уугуул иргэн, уугуул иргэний эрх (indigenous people right) гэдэг ойлголт ярих нь тийм ч тохиромжтой биш байна. Учир нь уугуул хүн ард гэх ойлголт нь Европчуудын газар зүйн их нээлт гэж нэрлэгддэг үйл явц болоод колонилолтой холбоотой европчууд нээсэн болон колонилолсон нутгийн хүн ардыг нэрлэж байсан уламжлалаас үүдэлтэй (Béteille 1998) юм. Өөрөөр хэлбэл тодорхой бүс нутаг болох Америк, Африк, Австрали тивийн зарим хэсгийн ард түмнийг энэ нэршлээр нэрлэдэг хүчтэй уламжлал бий. Монгол Улсын түүх, соёлын агуулга, контекст дээрх бүс нутгаас огт өмнөө тул энэ мэт нэршлийн утгыг мэдэлгүйгээр, хамаагүй шууд хуулбарлан хэрэглэх нь учир дутагдалтай юм.

Монгол нутаг дахь казак түмэн нь 100 гаруй жилийн өмнө өнөөгийн Шинжаан хавиас нүүр ирсэн ард түмэн бөгөөд тухайн үед өнөөгийн улс төрийн хил хязгаар нарийн тодорхой тогтоогүй байсан үе байжээ. Улмаар монгол нутагт зөвлөлт засаг тогтож, олон зүйл зөвлөлтийн зааварчилгаагаар хэрэгжсэний нэг нь угсаатны бодлого юм. Зөвлөлтийн зөвлөгч нар монголыг тухайн үеийн ЗХУ шиг олон үндэстнээс бүртгэсэн гэсэн номлол гаргаж, нэг цул монголчуудыг олон янзын, ялгаатай угсаатны бүлэг болгож хуваасан (Мөнх-Эрдэнэ 2012) байна. Үүндээ ч казак түмнийг багтаан тухайн үеийн хэллэгээр монголын нэг ястан гэж үзэж байжээ. Гэвч казак түмэнд ястан юм уу эсвэл угсаатны бүлэг гэх нэршил бус үндэсний цөөнх гэсэн ангилалд илүү таарах байв.

Тэдний үндэсний цөөнх гэсэн статус, эрхийн асуудал 1990 оны ардчилсан өөрчлөлтийн дараа улам батжиж, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага тэдний дунд яригдан буй сэдвээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нь ч нэмэгдсэн юм. Тэдний үндэсний ухамсар ч идэвхжиж, эх хэлээрээ ярих, боловсрол олох, соёл уламжлалаа хадгалахын чухлыг ярих болов. Гадна, дотны харилцаа холбоогоо ч сайжруулж, зөвхөн монгол нутаг дэвсгэр бус хөрш зэргэлдээ Казакстан, Турк, Арабын улсуудтай ч холбогдох болж, "уугуул" гэж нэрлэсэн Казакстан улсад очиж амьдрах, иргэншил авах хөдөлгөөн ч өрнөв.

Гэвч тус улсад очсон иргэдийн нөхцөл байдал тааруу, Оралмэн (oralman), кандас зэрэг нэр хоч зүүх, тодорхой зэрэглэлд орж, хаанаас ирснээрээ байр суурь эзлэх, ажил хөдөлмөр эрхлэх нь ч шийдэгддэг байх зэрэг сонирхолтой харилцаанд орох болжээ. Үүнтэй зэрэгцэн Монгол Улсад казак түмний эх хэл,

соёлыг хүндэтгэх, соёлын эрхээ эдлэх нөхцөлөөр хангах үүднээс хэд хэдэн санаачилга өрнөв. Тухайлбал, эх хэлээрээ боловсрол эзэмших боломжийг нэмэх, улмаар хос хэлний бодлого, хөтөлбөрийн асуудал яригджээ. Өнөөгийн байдлыг өнгөц харахад казак түмэн эх хэлээрээ боловсорч, эх хэлээ ашиглахад ямар нэгэн саад, тотгор байхгүй мэт харагдана. Гэвч бодит байдал дээр хос хэлний бодлого бүтэлгүйтэж, дийлэнхдээ казак хэлээр л боловсрол олж авснаар зөвхөн казак эсвэл монгол хэлээр тун бага ойлгодог бүлэг бий болжээ. Их сургуулийн суралцах зарим казак оюутан монгол их тааруу ойлгодог, улмаар хичээлээсээ хоцрох, амжилтгүй сурах нөхцөл болоод байна. Сүүлдээ их сургуульд казак оюутанд зориулсан монгол хэлний хичээл орох тухай ч асуудал хөндөгдөх болов.

Хэдийгээр эх хэлээрээ боловсрол эзэмших эрхийг нь хангаж өгч байгаа ч нөгөө талд хос хэлний боловсролын бодлого алдагдаж эсвэл төр анхааралгүй орхигдуулснаараа тухайн казак иргэдийн соёлыг эрхийг ноцтой зөрчиж буй нэгэн зөрчил энд илэрч байгаа нь тухайн хүн зөвхөн казак хэлтэй орчинд л амьдрахаас аргагүй болсон нөхцөл байдлаас харагдана. Энгийн жишээгээр казак хүүхэд эх хэлээрээ боловсрол олж, цаашаа Казакстан явах эсвэл Баян-Өлгий аймагтаа л байх сонголт "үлдээд" байна. Монгол Улсын бусад хэсэгт чөлөөтэй амьдрах, зорчиход хүртэл бэрхшээлтэй болж өөр бусад гадаад хэл сурахгүй л бол энэ байдлаасаа гарч чадахгүй байсаар байх нь. Энгийн иргэдийн дунд ч гэсэн казак хэл мэдэхгүй тул тэднийг ойлгохгүй, ойлгохгүй тул харилцахдаа эргэлзэх, эргэлзэх тул цэрвэх, хардах, янз бүрээр гоочлох зэрэг хүмүүнлэг бус хариу үйлдэл гарах байдал ажиглагдаад байна. Ийнхүү төрөөс тэдний амьдрал орчныг "санаатай/санамсаргүй" хязгаарлах нь олон сөрөг үр дүн авчрахуйц болжээ.

5.4. Хөгжлийн бодлого, төсөл, хөтөлбөр ба соёлын эрх

Хөгжил гэдэг хөндлөнгийн оролцоо, евро-америк төвт үзэл санаа юм. Энэ ойлголтыг судалдаг Хөгжил судлалын ухаанд дээрхтэй холбоотой олон судалгаа бий ч манай улсад тэр бүр нэвтэрч, нийтийн хэлэлцүүлэг бүү хэл эрдэм шинжилгээний эргэлтэд ч бараг ороогүй байгаа нь харамсалтай. Энэхүү хөгжлийн номлол ёсоор бол Барууныхан, аль нэг хүчтэй олон улсын байгууллага, үндэстэн дамнасан корпорац, хөгжлийн төсөл, хөтөлбөр аль нэг ард түмнийг, улсыг, хөдөөг, орон нутгийг, тосгоныг хөгжүүлэхээр ирдэг. Түүнээс аль нэг ард түмэн "бид хөгжих ёстой" гэж доороосоо санаачилга гаргах нь бага. 1948 оныг

хүртэл англи хэлний underdeveloped буюу хөгжил буурай, developing буюу хөгжиж буй гэх үг хэллэг ойлголт өнөөгийнх шиг ийм өргөн дэлгэр хэрэглэгддэггүй байжээ. Өнөө энэ ойлголт түгэн дэлгэрч, ялангуяа Барууны бус нийгэм-соёлыг бүрэн төлөөлөх хэмжээнд хүрээд байна. Нэг төрлийн мэдлэгийн колоничлолын жишээ болсон хөгжил гэх энэ ойлголт нь дээрээсээ бий болж, доошоо нэвтрэн эцэстээ угаасаа, цаанаасаа тэнд байсан, "жас ёсны" мэтээр ойлгогдох болжээ. Тиймээс ч олон судлаач хөгжлийн энэ хөндлөнгийн оролцоог судалж, маргаан мэтгэлцээн өрнүүлсээр байна. Харамсалтай нь манай улсад энэ чиглэлийн судалгаа тун бага төдийгүй асуудлын мөн чанарыг ч олж харалгүй өнгөцхөн таньж мэдсэн хэлбэртэй байна гэж дүгнэж болохоор байгаа юм.

Хөгжил судлал болоод антропологийн ухааны үүднээс хөгжил гэдэг нь "улс орон, тусламжийн байгууллага, иргэдийн нийгмийн хөдөлгөөний түвшинд эдийн засгийн өсөлт, тодорхой бодлого, төлөвлөгөөгөөр дамжуулан нийгэм, эдийн засаг өөрчлөгдөх үйл явц. Эдгээр өөрчлөлт нь хүмүүс эерэг, сөрөг олон нөлөөтэй төдийгүй ямар нэгэн үзэл суртал, хэлэлцүүлэг бүтээх цуврал үйл явдал, үйл ажиллагаа байдаг" (Gardner болон Lewis 2015, 44) гэж үздэг. Үнэхээр хөгжил гэсэн нэртэй үйл ажиллагаа бүрийн цаана, хөндлөнгийн оролцоо, хандив-тусламж, зээл, бодлогын зөвлөмж зэрэг байдаг. Энгийн үгээр бол манай улсын баталсан 800 гаруй хууль болон бусад албан бичиг баримтад хөгжлийн байгууллагын зөвлөгөө, хөндлөнгийн оролцоо ороогүй нэг ч хууль, баримт бичиг байхгүй гэсэн үг. Үгүй гэхэд л "гадны туршлага, хөгжсөн орны жишээ" гэх мэт шидэт үгээр халхавчилсан, ямар нэгэн нөлөө байгаа гэсэн санаа юм. Үүнийг улс, хүн хоорондын жирийн харилцаа, нэг нэгнээсээ суралцдаг зарчим зэрэгтэй хольж хутгаж болохгүй юм.

Тиймээс хамгийн чухал нь том Х/хөгжил ('big D' Development), жижиг х/хөгжил ('little d' development) хоёрыг сайтар ялгах хэрэгтэй (Hart 2001, 650). Том Х/хөгжил гэдэг нь Дэлхийн II дайны дараа гуравдагч ертөнцийн улсуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох болсон Хүйтэн дайн, колоничлолоос салгах агуулга, ойлголттой төсөл хөтөлбөрийн тухай байдаг бол жижиг х/хөгжил нь түүхэн үүднээсээ ч газар зүйн байрлал үүднээсээ ч харилцан адилгүй байдаг капиталист тогтолцооны хөгжлийн тухай юм. Иймээс бидний ярьж буй хөгжил гэдэг ганц үг боловч их ерөнхий ухагдахуун яг юу өгүүлээд байгааг анхаарч, анзаарч байх хэрэгтэй болж байна.

Манай улсын хувьд хөгжлийн болон тусламжийн олон төсөл хөтөлбөр, олон улсын байгууллага төрийн зарим байгууллагаас дутуугүй эрх сүр, нөлөө хүрээтэй болсон байгааг судлаач И.Бямбабаатарын "Хөгжлийн эрэлд: Мал аж ахуй, байгаль хамгаалах салбар дахь хөгжлийн байгууллагын хөндлөнгийн оролцоо" судалгаанаас уншиж болно. Ялангуяа мал аж ахуй, байгаль хамгаалах салбарт өнгөрсөн 30 жил хэрэгжсэн гадны төсөл ямар үр дүнтэй, нөлөө тусгалтай байсныг энэ жишээгээр нийгмийн бусад салбарыг харьцуулан харах боломж уг судалгаанд байна. Өөрөөр хэлбэл хүн аливаа зүйлийг таньж мэдэхдээ "тэр зүйл оршиж байгаа, хэрэгтэй, үнэн-зөв болохоор нь таньж мэдээд байгаа юу эсвэл "ийм зүйл байдаг юм, хэрэгтэй шүү, үнэн-зөв шүү" гэж хэн нэгэн хэлсэн учраас таньж мэдээд байгаа юу гэдэг мэдлэгийн шинжлэх ухааны асуудлаа байнга бодож байх хэрэгтэй гэсэн үг. Энэ үүднээсээ Монгол Улсад хөгжил гэх ойлголт нь үнэмлэхүй "үнэний дэглэм" (regimes of truth) (Foucault 1977) болсон. Хөгжихийн төлөө тодорхой золиос гаргах ёстой тул нийгмийн зарим нэг таагүй асуудлын талаар чимээгүй өнгөрөх тухай номлол монголын хэсэг сэхээтний дунд бий (илүү дэлгэрэнгүйг Munkherdene 2018-ээс үзнэ үү). Эсвэл сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр газар аваад байгаа шиг "эрчим хүчний хараат байдлаас гарахын тул Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг заавал барих хэрэгтэй. Нутгийнхан юу гэж ярих нь хамаагүй, улсын хөгжлийн төлөө тэд чимээгүй байх ёстой" гэх мэт яриа мэтгэлцээн дээрхийн тодорхой жишээ юм.

Энэ асуудалтай холбоотойгоор манай улсад дэлгэрээд байгаа өөр нэг кэйс бол уул уурхай, дэд бүтцийг хөгжлийн төслийн ашиглах газар нутагт соёлын өвийн тандалт, хайгуул судалгаа хийх болсон туршлагын кэйс юм. Соёлын өвийн тухай хуулиараа ийм хайгуул, судалгаа хийж, ямар нэгэн зөрчил, гэмтэл, хор хохирол учруулахгүй бол уг төсөл цааш үргэлжлэх ёстой болдог Гэтэл зарим судалгааны байгууллага, эрдэмтэд энэ ажлыг "нөөц баялаг-боломж бололцоо" гэж үнэлэн, үндсэн ажлаасаа илүү энэ ажилдаа шамдан, соёлын өвийн дурсгалыг авран хамгаалах нь нэн тэргүүний зорилт уу эсвэл зохих төлбөрөөр уг ажлыг хийх нь тэргүүлэх ач холбогдолтой юу гэдэг нь ялгахад төвөгтэй байдалд орчихоод байна (Bumochir & Munkherdene 2019). Нэгэнт л компани ажлаа үргэлжлүүлэх зорилготой тул зарим нэг соёлын өвийн асуудлыг "хойш тавих" нөхцөл байдал ч бүрэлдээд байгаа нь нууц биш. Энэ мэт төсөл, ажил нь ихэвчлэн "улс орны хөгжлийн төлөө, эдийн засагт үр нөлөө ихтэй" гэсэн үзэл суртлын, сурталчилгааны арга ашиглах нь их байдаг. Өөрөөр хэлбэл бид "хөгжинө, хөгжил

хүрнэ" гээд юу оронд нь өгч байгаагаа анхаарч байхгүй бол ирээдүйд нэгэн төрлийн соёлын эрхийн асуудал хөндөгдөх урьдач нөхцөл бүрэлдээд байгааг энэ кэйс харуулж буй юм.

5.5. Зохиогчийн хийгээд оюуны бүтээлийн эрхийн зөрчил

Зохиогчийн эрх хийгээд оюуны бүтээлийн эрхтэй холбоотой асуудал, маргаан эрдэм шинжилгээний гэлтгүй нийтийн талбарт их байна. Судлаач Н.Алтантөгсийн (2020) МУИС, ШУА-ийн судлаачдаас авсан судалгаанд оролцогсдын дөнгөж 15,2% нь ёс зүйн зөрчил өртөж байгаагүй, 62% нь өртөж байсан гэж хариулсан байна. Ёс зүйн зөрчил гэж юуг үзэж буйг тандсан асуултад хариулагчдын 69% нь зохиогчийн эрхийн зөрчлийг дурджээ. Эргээд зохиогчийн эрх зөрчигдсөн хүмүүсийн хэдэн хувь нь гомдол гаргаж байсан тухай тандахад дөнгөж 7,3% нь гомдол гаргасан үр дүн гарчээ. Энэ бэсрэг судалгаа шинжлэх ухааны салбарт буй ёс зүйн асуудал, зохиогчийн эрхийн зөрчлийн тухай ихийг өгүүлж байна. Энэ сэдвийн талаар дорвитой, тухайлж хийсэн судалгаа хомс тул тэр бүр мэдээлэл ховор байгаа нь тус асуудлыг ярихгүй орхиж болно гэсэн үг биш.

Зөвхөн оюутан, анхлан суралцаг бус мэргэжлийн гэгдэх судлаач, багш нарын дунд ийм асуудал байгаа нь соёлын эрхийн нэгэн зөрчил юм. Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16.8 дахь хэсэгт “соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасан нь зохиогчийн болон түүнд хамаарах эрхийг хамгаалах үндсэн суурь зохицуулалт энд хөндөгдөж байна. Зохиогчийн эрхийн тухай хуулийг шинэчлэн найруулж, 2021 оны 5 сарын 6-ны өдөр баталсан бөгөөд хуулийн зорилт болох “шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлтэй холбоотой үүсэх зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах, соёл, урлагийн бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор бүтээлийг ашиглах эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан нь энэ кэйстэй холбогдож буй юм.

Гэвч энэ төрлийн асуудлаар хэн нэгэн гомдол гаргалаа ч ёс зүйн эсвэл хуулийн хариуцлагын алийг хэрэглэх нь нэг мөр тогтоогүй байдал байгаа аж. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм, Багш профессорын ёс зүйн дүрэм зэрэг ёс зүйн кодууд байгаа ч түүнийг хэрэгсэж үздэг, Ёс зүйн хороогоо хуралдуулж зохих шийтгэл оноодог практик, туршлага хангалттай тогтоогүй

байна. Энэ байдал нь эргээд хэн ч хэний ч зохиогчийн эрхийг зөрчих, улмаар хоёр хүний хувийн хэрүүл маягтай болгон гуйвуулаад, хариуцлагаас мултрах боломж өгч байгаа харамсалтай жишээ хэд хэд тохиолдов.

Үүнээс гадна дурдахгүй өнгөрч болохгүй кэйс бол оюуны бүтээлийн эрхийн зөрчил болно. Уран бүтээлчдийн бүтээлийг хууль бусаар хуулж, интернет орчинд байрлуулах, CD хэлбэрээр зарах зэрэг үйлдлийн тоо улам нэмэгдэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдэл, гаргалгаа гарах гэж цаг хугацаа их зарцуулдаг төвөгтэй байдал бий болчихоод байна. Төрийн байгууллагууд энэ бүх зөрчлийн эсрэг аян зарлах, сурталчлан таниулах ажил хийдэг ч үр дүн ямар байдаг талаар мэдээлэл олдсонгүй. Ямартай ч Боловсрол, шинжлэх ухааны сайд өнгөрсөн намар хуурамч диплом, оюуны бүтээлийн хулгайтай (plagiarism) тэмцэнэ гэдгээ ил зарлах хэмжээнд хүртэл энэ асуудал газар аваад байгаа нь "бүтээл тууривах, түүнийхээ үр шимийг хүртэх" соёлын эрхийн асуудал болоод байна. Тиймээс нэгэнт баталсан дүрэм журам, ёс зүйн код, хуулийн заалт зэргээ баримтлан энэ мэт хэрэгт хариуцлага оноох, байгаа баримт бичиг хангалтгүй гэж үзвэл засан сайжруулах ажлын нэн даруй хиймээр байна. Гэвч энэ бүх асуудлын гаргалгаа, шийдэл нь энэ төрлийн хэрэгт орооцолдогчийг шийтгэх, хариуцлагажуулахаас эхэлдэг гэдгийг сайтар анхаарах учиртай болоод байна.

6. Дүгнэлт, зөвлөмж

6.1. Дүгнэлт

Нийгэм-соёлын антропологийн онол, арга зүйг баримтлан тус судалгааг хийж гүйцэтгэлээ. Судалгаа хийх болоод тайлан бичих арга маяг энэ төрлийн тайлан судалгааны хэлбэр, загвараас өөрөөр янзтай болсон байх магадлалтай. Ингэхийн учир нь бусдаас ялгарах, онцгойрох, өөр болох гэсэн хүсэл бус өөр хувилбар, ялгаатай санал гаргаж байх ёстой эрдэм шинжилгээ, судалгааны үндсэн зарчмаа дагасан төдий юм. Мөн судалгааны аргын тухай хоёрдугаар хэсгийн мэдээлэл тодорхой хэмжээнд энэ төрлийн судалгаа, тайлан бичих соёлд өөр хувилбар, санал санаачилга болох буй за.

Судалгааны явцад илэрсэн таван кэйс жишээ урьд өмнө манай улсын судалгааны хүрээнд харьцангуй бага яригдаж байсан сэдэв болов уу. Энэ маягаар бага танигдаж, анхаарлын гадуур байсан нь эдгээр асуудал байхгүй байсан гэсэн үг биш юм. Тиймээс дээрхийн мэт асуудлыг олж харах, нээх нь судалгааны, судлаачийн үүрэг, гол ажил байдаг. Өөрөөр хэлбэл байгаа байдлыг юм уу эсвэл өмнө ямар нэгэн байдлаар хийгдсэн судалгааг товчлон тоймлох, дахин давтан эшлэх гэхээсээ илүү бүтээлч байдлаар асуудлыг судлан, өөр бусад сэдэв яриа байгааг нээж олох гэж оролдсон нэгэн оролдлого энэ тайлан боллоо.

Дээрх таван кэйсээс хамгийн их анхаарал хандуулах хэрэгтэй кэйс бол үндэсний цөөнхийн, соёлын өвийн болон зохиогчийн/оюуны өмчийг эрхийн асуудал гэж үзэж байна. Учир нь эдгээр асуудал тэр бүр яригддаггүйн дээр мэргэжлийн болоод төрийн байгууллага ч бага анхаарч байгаа судалгааны явцад илэрсэн юм. Энэ удаа соёлын эрхийн тухай судалгааг зориглон хийсний адилаар эдийн засгийн, нийгмийн, соёлын эрхийн тухай хамтатгасан судалгаа хийх, уг эрхийг нийт багцаар нь олон таниулах ажил зохиох боломжтойг уг судалгаа давхар харуулаад байна.

Дөрөвдүгээр хэсэгт тоймлон танилцуулсан, соёлын эрхийн тухай англи хэлээр эрдэм шинжилгээний судалгааг монгол дахь энэ төрлийн судалгаанд ашиглах, улам дэлгэрүүлэн, хэлэлцүүлэг маргааны хүрээний эргэлтэд оруулбал бидний судалгааны бүтээлч байдалд эерэг нөлөөтэй байх нь дамжиггүй. Ингэхдээ "гадны туршлага, шилдэг жишээ" гэх мэт "уламжлал" аргаараа тэрхүү

судалгаануудыг харж, идэвхгүй дагалгүй харин харьцуулж жишиж болох, яриа мэтгэлцээнийг баяжуулах нэгэн сонголт гэж үзвэл зохилтой. Антропологийн үүднээс хүний эрх, соёлын эрх гэх ойлголтыг маргаантай талыг хөндөж буй дээрх судалгаанууд зөвхөн эрдэм шинжилгээ, академик ач холбогдолтой бус шинэ мэдлэг бүтээх, танилцуулах хэрэглээний ч гэсэн ач холбогдолтойг дахин сануулах юун.

6.2. Зөвлөмж

- Соёлын эрхийн ойлголтыг түгээхийн тулд уг эрхийн тухай чанартай эрдэм шинжилгээний бүтээл, судалгааг монгол хэлнээ орчуулах
- Соёлын эрхэд багтах сэдэвчилсэн жагсаалт үүсгэж, тус бүрийг судлах
- Зөвхөн соёлын эрх гэлтгүй хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрх гэсэн нэгдсэн ойлголтыг хамтад нь анхаарч, олон нийтэд таниулах
- Нэгэнт судлан тогтоож, тодорхой цаг хугацаа, нөөц боломжоо зарцуулсан соёлын эрхтэй холбогдож болохуйц асуудал, кэйсээ үргэлжлүүлэн судлах, нийтийг хамарсан маргаан мэтгэлцээний хүрээнд идэвхтэй оруулах, санал шийдэл гаргах
- Уг тайланд онцолсон таван кэйсийг анхааралдаа авч бодлого, төлөвлөлтөд тусгах
- Дээрхийн мэтээр Монгол Улсын иргэний соёлын эрх зөрчигдөж болохуйц, асуудал бэрхшээл үүсэхүйц нөхцөл байдлыг урьдчилан тогтоож, үнэлэх
- ЮНЕСКО зэрэг хүчтэй, эрх бүхий байгууллагын соёлын өвийн жагсаалтад өвөө бүртгүүлэх ажлаа уралдаан, тэмцээн мэт харж, мэргэжилтэн гэсэн хэсэг хүнд даатгалгүй нухацтай, олон талаас нь харж, ирээдүйд үүсэх эрсдэлийг тал бүрийн мэргэжилтний багаар хэлэлцэн, үнэлүүлдэг байх
- Төрөөс хэрэгжүүлж буй соёл хамгаалах, түгээх ажлыг үнэлдэг болох. Ийн үнэлэхдээ уламжлалт маягаар эерэг, сөрөг тал гэсэн хязгаарлагдмал хүрээгээр бус бодлого, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хөндөж болох нөхцөл байдал бий эсэхийг тандах
- Олон улсын байгууллага, хөгжлийн төсөл хөтөлбөрийн ашиг сонирхлыг таньж мэдэх, түүнийг шууд хэрэгжүүлэх, дагахаасаа илүү улсын, иргэний эрх ашигтай зөрчилдөх эсэхийг шүүн тунгаадаг тогтолцоо бүтээх

- Хөгжлийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тодорхой шүүлтүүр шалгууртай болох. Хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн үнэлгээг эрх бүхий байгууллагатай хамтран хийж, хангалтгүй үнэлгээ авсан олон улсын болон төрийн бус байгууллагын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх санаачилгад анхаарал болгоомжтой ханддаг болох
- Үндэсний цөөнхийн эрхийг асуудал нухацтай хандаж, санамсаргүй болон санаатайгаар тэдний эрхийг орхигдуулах нөхцөл үүсгэхгүй байхад анхаарах
- Үндэсний цөөнхийн асуудал, тэр дундаа Цаатан иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаар тухайлсан судалгаа хийж, санал зөвлөмж боловсруулан, албан бичиг баримтад тусгах
- Зохиогчийн болон оюуны өмчийн эрхийг талаарх хууль эрх зүйн баримт бичгээ шинэчлэх, гарсан зөрчлийг шийддэг хэвшил тогтоох ажлыг зохион байгуулах

7. Ном зүй

- Ahearn, A., & Namsrai, B. (2021). Filling a Hole? Compensation for Mining-Induced Losses in the South Gobi. In *The Impact of Mining Lifecycles in Mongolia and Kyrgyzstan* (pp. 76-93). Routledge.
- Baderin, M. A., & McCorquodale, R. (Eds.). (2007). *Economic, Social and Cultural Rights in Action*. Oxford: Oxford University Press.
- Barfield, T. J. (1989). *The Perilous Frontier: Nomadic Empires and China*. London: Blackwell.
- Bernard, H. R. (2017). *Research Methods in Anthropology: Qualitative and Quantitative Approaches*. Rowman & Littlefield.
- Béteille, A. (1998). The Idea of Indigenous People. *Current Anthropology*, 39(2), 187-192.
- Bumochir, D., & Munkherdene, G. (2019). Revitalisation of Cultural Heritage in Mongolia, *Inner Asia*, 21(1), 83-103.
- Dulam, B. (2017). The Afterlife of Nomadism: Pastoralism, Environmentalism, Civilisation and Identity in Mongolia and China. In A. Ahearn, T. Sternberg, & A. Hahn (Eds.), *Pastoralist Livelihoods in Asian Dryland: Environment, Governance and Risk* (1st ed., pp. 17–40). Winwick: The White Horse Press.
- Eide, A. (2001). Economic, Social and Cultural Rights as Human Rights. In *Economic, Social and Cultural rights* (pp. 9-28). Brill.
- Eide, A., & Rosas, A. (2001). Economic, Social and Cultural Rights: A Universal Challenge. In *Economic, Social and Cultural Rights* (pp. 3-7). Brill.
- Engle, K. (1999). Culture and Human Rights: The Asian Values Debate in Context. *NYUJ Int'l L. & Pol.*, 32, 291.
- Foucault, Michel (1977). *Discipline and Punish: The Birth of the Prison*, New York: Random House.
- Gardner, K., & Lewis, D. (1996). *Anthropology, development and the post-modern challenge*. Pluto Press.
- Geertz, C. (1973). *The Interpretation of Cultures*. Basic books.
- General Assembly of the United Nations. (1948). Universal Declaration of Human Rights. *UN General Assembly*, 302(2), 14-25.
- General Assembly of the United Nations. (1966b). *The International Covenant on Economic, Social and Cultural Rights (ICESCR)*. UN General Assembly.

- General Assembly of the United Nations. (1966a). *The International Covenant on Civil and Political Rights (ICCPR)*. UN General Assembly.
- Hart, G. (2001). Development critiques in the 1990s: culs de sac and promising paths. *Progress in Human Geography* 25, 605–614.
- Khazanov, A. M. (1994). *Nomads and the Outside World*. University of Wisconsin Press.
- Kukathas, C. (1992). Are There Any Cultural Rights? *Political theory*, 20(1), 105-139.
- Levy, J. T. (1997). Classifying Cultural Rights. *NOMOS: Am. Soc'y Pol. Legal Phil.*, 39, 22.
- Lury, C. (2002). *Cultural Rights: Technology, Legality and Personality*. Routledge.
- Müller, A. (2017). Limitations to and Derogations from Economic, Social and Cultural Rights. In *Economic, Social and Cultural Rights* (pp. 113-158). Routledge.
- Munkherdene, G. (2018). The formation and distribution of procapitalist perspectives in Mongolia. *Central Asian Survey*, 37(3), 372-385.
- Mutua, M. (2002). *Human rights: A Political and Cultural Critique*. University of Pennsylvania Press.
- Owen Lattimore. (1940). *Inner Asian Frontiers of China*. American Geographical Society.
- Preis, A. B. S. (1996). Human Rights as Cultural Practice: An Anthropological Critique. *Hum. Rts. Q.*, 18, 286.
- Roth, K. (2004). Defending Economic, Social and Cultural Rights: Practical Issues Faced by an International Human Rights Organization. *Human Rights Quarterly*, 26(1), 63-73.
- Sen, Amartya. (1999). *Development as Freedom*. Oxford University Press.
- Silverman, H., & Ruggles, D. F. (2007). Cultural Heritage and Human Rights. In *Cultural Heritage and Human Rights* (pp. 3-29). Springer, New York, NY.
- Stamatopoulou, E. (2007). Cultural rights in international law: Article 27 of the Universal Declaration of Human Rights and beyond.
- Stamatopoulou, E. (2012). Monitoring cultural human rights: the claims of culture on human rights and the response of cultural rights. *Hum. Rts. Q.*, 34, 1170.
- Stavenhagen, R. (2001). Cultural rights: a social science perspective. In *Economic, Social and Cultural Rights* (pp. 85-109). Brill.

- Sternberg, T., Ahearn, A., & McConnell, F. (2020). From conflict to a community development agreement: A South Gobi solution. *Community Development Journal*, 55(3), 533-538.
- Sternberg, T., Toktomushev, K., & Ichinkhorloo, B. (2021). *The Impact of Mining Lifecycles in Mongolia and Kyrgyzstan*. (T. Sternberg, K. Toktomushev, & B. Ichinkhorloo, Eds.), *The Impact of Mining Lifecycles in Mongolia and Kyrgyzstan* (1st ed.). London and New York: Routledge, Taylor&Francis Group.
- Tay, S. S. (1995). Human rights, culture, and the Singapore example. *McGill LJ*, 41, 743.
- Tsetsentsolmon, B. (2014). The 'gong beat' against the 'uncultured': contested notions of culture and civilization in Mongolia. *Asian Ethnicity*, 15(4), 422-38.
- Tsetsentsolmon, B. (2014). Хуваалцах уу, үгүй юу: Биет бус соёлын өвийн тухай монголчуудын маргаан. *Studia Ethnologica*, 21(22), 246–54.
- Tsetsentsolmon, B. (2015). Music in cultural construction: nationalisation, popularisation and commercialisation of Mongolian music. *Inner Asia*, 17(1), 118–40.
- Tylor, Edward. (1871). *Primitive Culture: Researches into the Development of Mythology, Philosophy, Religion, Language, Art and Customs*. London: Murray.
- UNESCO. (2003). *Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage*. Paris: UNESCO.
- Varis, P. (2015). Digital ethnography. In *The Routledge handbook of language and digital communication* (pp. 55-68). Routledge.
- Wiessner, S. (2011). The cultural rights of indigenous peoples: achievements and continuing challenges. *European Journal of International Law*, 22(1), 121-140.
- Wilson, R. A. (1996). Human rights, culture and context: Anthropological perspectives.
- И.Бямбабаатар, Г.Цогзолмаа. (2021). Нүүдэлч малчдын уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хүний эрхийн зөрчил, шийдэл. *Хүний эрх*, 2(58), 27-40.
- И.Бямбабаатар. (2021). *Хөгжлийн эрэлд: Мал аж ахуй, байгаль хамгаалах салбар дахь хөгжлийн байгууллагын хөндлөнгийн оролцоо*. МУИС Пресс.
- Монголын Криминологичдын Холбоо. (2022). *Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн эрх зүйн антроплогийн судалгаа*. Улаанбаатар.

- Мөнх-Эрдэнэ, Г. (2015). Аль соёл судлал вэ: талбараа тодорхойлох шаардлага. *Орчин үеийн монголын хэл, түүх, соёлын судалгаа*, 3(1), 153-165.
- Мөнх-Эрдэнэ, Л. (2012). Монголын тусгаар тогтнолын ёгт үр дагавар: Монголчуудыг Монголжуу, Монгол улсыг олон ястны болгосон нь. С.Чулуун (эмх.), *Монголын тусгаар тогтнол ба монголчууд*. Хуудас 25-40. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Н.Алтантөгс. (2020). Монгол дахь шинжлэх ухааны ёс зүйн тулгамдсан асуудал. *Шинжлэх ухаан-амьдрал*, 03(358), 63-79.
- ХЭҮК. (2004). *Монгол Улс дах хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл-2003*. Улаанбаатар.
- ХЭҮК. (2010). *Монгол Улс дах хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл-2009*. Улаанбаатар.
- ХЭҮК. (2013). *Монгол Улс дах хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл-2012*. Улаанбаатар.
- ХЭҮК. (2017). *Монгол Улс дах хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл-2016*. Улаанбаатар.
- ЮНЕСКО. (2005). *Соёлын Илэрхийллийн Олон Төрлийг Хамгаалах Болон Хөхиүлэн Дэмжих Тухай Конвенц*. Парис: ЮНЕСКО.

8. Хавсралт

8.1. Соёлын салбарын мэргэжилтний ярилцлагын жишээ

За хамгийн эхлээд цаанаас өгсөн соёлын эрх гэсэн нэр томъёо хэллэг байна. Үүний ер нь ерөнхий байдал таны мэдэж байгаагаар бид нар ийм нэр томъёо хэрэглэж байна уу? Хууль эрхзүйдээ тусгаж байна уу? Албан бичиг баримтад байна уу?

За соёлын эрх гэхээр мэдэж бид нарын хувьд homogeneous юм уу? нэг үндэстнээс бүрэлдсэн, социализмын ойлголтоор халх угсаатан нь казак дотор ястан нь гэдэг нөхдүүдээрээ арай давамгайлсан, олон ястантай гэдэг юм уу? гэхдээ Монгол үндэстэн гэдэг утгаар нь аваад үзэхээр соёл гэдгээ бид нар юу гэж ойлгож байна гэдгээ харах шаардлагатай.

Соёл гэхээр анторпологийн нийгмийн ухаанд авч үздэг нийгэм соёл гэдэг утгаараа авч үзэх юм уу? эсвэл тодорхой хэмжээнд indigenous буюу үнэгдсэн үндэсний байгууллагын баталсан уугуул иргэдийн эрхийг хамгаалах конверцын хүрээнд харах ёстой юу гэдэг асуудал юм.

Хоёрдугаарт нь уугуул иргэдийн соёл эрхийн тухай ярихаар колончлолын үеийн асуудал гарч ирнэ. Колончлолын үзэл санаанууд гарч ирнэ. Тэгэхээр өөрөө соёлын эрх гэдэг ойлголт нь нэгт эрх гээд ярьж байгаа болохоор эрхийг хэрэгжүүлэх гээд байгаа нөхдүүд, эрхийг нь хаана боогдуулаад байгаа ч юм шиг нөгөө хэсэг гарч ирнэ. Урьд нь энэ колончлолын үед колончилдог нөхдүүд мань тухайн уугуул ард иргэд дээр очоод тухайн ардыг өөрөөрөө амьдрахыг арга замыг хаана боогдуулдаг асуудал байж. Энэ ялангуяа энэтхэг дээр хамгийн их тохиолдож байсан зүйлс юм. Английн колончлогчид тэнд очсон энэтхэгүүдийг ойлгодоггүй, цэргийн эрхтэн дархтнууд язгууртнуудыг өөртөө татаж өөрсдийн үзэл суртал нэвтрүүлээд өөрсдийн хяналтыг тогтоогоод явсан. Хамгийн гол нь хууль дэг журмыг тогтоогоод тэнд байгаа хүмүүсийн амьдрах арга хэлбэрийг өөрчилсөн. Үүнд соёлын эрхийн асуудал яригдаж байна. Бид та нарыг ирэхээс өмнө гэртээ өвсөн овоохой ч бай, шавраар байшин бариад амьдардаг байсан та нар ирээд энэ буруу байна модон байшин барь гээд уналаа. Би нутагтаа уламжлалт соёл хэлбэрээрээ амьдрах эрхийг зөрчөөд байна. Энийг бол мэдээж харьцангуй сүүлд ярьж эхэлсэн л дээ 70 80 аад оны үеэс.

Тэр үеэс амьдрах амьжиргааг нь зааж байсан, яаж амьдрах яаж баярлах цэнгэхийн хүртэл заасан яаж биеэ авч явахын заадаг өөрөөр хэлбэл хөндлөнгөөс оролцоод ирэхээр л хүний эрх нь зөрчигдөөд уламжлал соёлынхоо дагуу явах асуудал сөргөлдөж гарч ирээд эхэлсэн. Миний соёлын эрх гэсэн асуудал гарч эхэлсэн. Тэгэхээр үнэхээр тийм юм байна уу? гэхээр байна. Африк тэр чигээрээ байна арабын улсууд байна, ираны дайн самуун радикал хэт үзэл рүү автсан барууны хэт их нөлөө 60 70 аад онд автсан, колончлолд байсан үеийг эсэргүүцсэн, хэт үзэлтнүүд нь эрхийн аваад л ийм айхтар орон болгоод хувиргачихсан шүү дээ. Тэрийг бид нар түүхээс нь ч мэднэ уран зохиолоос хүртэл мэднэ

Тэгэхээр Монголд энэ асуудал байна уу гэдгийг ярих ёстой болж байна. Монголд байна уу? гэвэл байна гэж үзнэ. Бидний амьдардаг арга хэлбэрийг гадны нөлөөтэйгөөр тодорхой хэмжээнд өөрчиллөө. Өөрчилсөн процессыг 20 дугаар зууны үед 70 жилийн хугацаагаар бодож үзэх ёстой. Тэр хугацаанд социализм бүтээн байгуулна гэсээр зөвлөлтийн нөлөө асар их хурдтайгаар орж эхэлсэн. Зөвлөлтийн нөлөө гэхийн уу? социалист үзэл санааны нөлөөгөөр социалист хүн бүтээх тухай маш олон мэдлэг янз бүрийн соёл заншил орж ирсэн. Социалист орчин үе буюу modernization хүрээнд ахуйн соёл нэвтрэн нөгөө талаар уламжлалт байдлаар амьдрах арга хэлбэрийг хамгийн муу муухай зүйл юм шиг ухуулан байхгүй болгосон. Тэгээд үзүүлдэг зүйл нь хэдэн баримтад кино л байдаг. Ийм ядуу байсан уу? гэхээр ядуу байсан. Хаа сайгүй л ядуу байсан ш дээ орос ч ялгаагүй хятад хүмүүс өлсгөлөнгөөр үхэж л байсан. Тэр үеийн зургийг хараад л энэ үндэстэн мөхөж сүйрэхийн даваан дээр байхад зөвлөлтүүд ирж аварсан гэх домог шиг зүйл зохиосон, үүнийгээ хэт их улс төржүүлээд явчихсан. Үүний үр дүнд ЗХУ нөлөөтэй соёлын мэдлэг нь хүмүүст бодит мэдлэг болоод тогтчихсон. Үүний үр дүн бодит мэдлэг зан заншил тэр зүйлүүдийг мартаад түүнийгээ сэргээе гэхээр энэ дээр dvalomi буюу хоёрлосон маягтай мэдлэг бий болж итгэхэд хэцүү ацан шалаанд орчихсон. Бид эргээд сэргээе гэхээр аль нь туйлын үнэн соёл юм бол гээд асуудал нь төөрөөд алга болж байгаа юм.

Хувьсгалаас өмнө соёл ямар байсан юм. Манж чингийн үед ямар байсан юм гээд эргээд дахин бүтээх гээд түүхчид маань эргээд түүх ном судлаад тэгээд оролддог. Социализмын үед төрж өссөн хүмүүс тэр үед байсан орчин соёл хэв маягаа бас туйлын үнэн боддог дараан 90 оны үед баахан гадны дэвшилтэд үзэл санаа орж ирээд тэнд гарж ирж байгаа үнэт зүйл итгэл үнэмшил биеэ авч явах

байдал аж төрөх хүнтэй бас найзалж нөхөрлөхөөс авхуулаад энэ бүх итгэл үнэмшил урьднытайгаа зөрчилдөөд эхэлдэг. Энэ бүгд бас тус тусдаа байгаа юм биш, энэ бүгд маань тодорхой generation буюу үеүдэд дотор энэ нь арай илүү давамгайлсан гэсэн үг л дээ. Социализмын үеийн үзэл сэтгэлгээ нэг талд нь давамгайлаад магадгүй 70 он 60 оны хүмүүст социализмын үеийн сэтгэлгээ өөрсдийнхөн итгэл үнэмшил нь тогтчихсон, магадгүй 90 -ээд оноос хойш төрсөн хүүхдүүдийн хувьд зах зээлийн үеийн барууны маягийн ардчилал хүний эрхийг дээдэлсэн үзэл сэтгэлгээ давамгайлсан plural буюу соёлын олон янзын байдлыг давамгайлсан, үндсэн хууль хүний эрхээ хүндэтгэдэг үзэл санаа магадгүй 60 70% байна.

Харин социализмын тухай өвөө эмээгээсээ сонссон 10, 20% тай ч юм уу? ингээд хүмүүсийн доторх бодол өөр өөр байна. Нэг хүнд бол туйлын үзэл огт байхгүй байна. Нөгөө нүүдлийн соёлын мэдлэг социализмаас өмнөх юм бол бас тодорхой хэмжээнд тэр хүний оюун ухаан дотор байна. Дээд сургуульдаа заалгасан ч юм уу? өвөө эмээгээсээ сонссон ч юм уу? эд нар маань хоорондоо аль нь илүү давамгайлах бэ? гэсэн тэмцэл тулаан өрнөж байна л даа. Яг энэ үе дээр бидний эдийн засгийн буюу соёлын эрх гэсэн зүйл ороод ирж байгаа юм. Тэгэхээр бид нар нэг хүн дотор байж байгаа өөрийнхөн үзэл бодол нэг нь нөгөөгөө dominate буюу давамгайлж оршиж байгаа тэр үзэл бодлуудыг хооронд нь зөрчилдөх биш уралдуулах асуудал ярьж байгаа юм

Энэ нь үнэн энэ худлаа биш гэж харьцуулаа гэсэн үг үү?

Өөрөөр хэлбэл социализмын үеийн үзэл сэтгэлгээ нь 30 40% эзэлж байж магадгүй нөгөө талд нь хүний эрхийн асуудал, хүний эрх бол универсал гэж үзье гэтэл хувийнхаа өөрийнхөө эрх ашгийг нэгдүгээрт нийгмийн эрх ашгийг 2 дугаарт тавина гэсэн ийм нэг үзэл ороод ирлээ шүү дээ, энийг нөгөө талаараа барууны орнуудад аваад үзвэл энгийн асуудал. Гэтэл манай монгол улсад аваад харьцуулахад нөгөө хүний дотор байсан 30 40% байгаа байхгүй юу тэрэнд итгээд байдаг тэгэхэд нөгөө замаар яваад байдаг ялт ч байхгүй социализмын үеийн нийгмийн гэдэг эрх ашиг өндөрт байгаад байдаг энэ хоёр дунд нөгөө хүн маань ацан шалаанд орчихсон байж байгаа юм өөрөө ч мэдэхгүй. Тэр нь нөгөө гол хүн нийгмийн буюу нийтийн эрх ашгийг түрүүнд тавьдаг хүн болох өвөө эмээ нь орчинд нь байгаад байдаг. Гэтэл нөгөө хувийн эрх ашгаа дээгүүр тавих ёстой гэсэн үзэл санаа нь ажлын орчинд нь юм уу? найз нөхдийн дунд яваад байдаг.

Тэгэхээр энэ хүн хаана явах бэ? гэдэг нь хувь хүн дотроо өөрөө ацан шалаанд орж байгаа юм.

Нөгөө талдаа дахиад нэг зүйл нь юу бэ гэхээр бид нарын амьдарч байгаа орчноос шалтгаалаад энэ чинь өөр өөр болоод явчихдаг. Анторпологичид бол мэднэ moral economy гээд бид нар байнга ярьдаг, нөгөө талд нь individualist, market economy гээд хоёр зүйлийг эсэргүйцүүлэхгүйгээр аль нь алийгаа багтаадгийн аль алиндаа нөлөөлдгийн , аль нь харилцан ойлголцож явдгийн, аль хаанаас ирсэн гэдгийг бид нар судалдаг. Moral economy гэж юу юм бэ? Бид нарын мэддэгээр хүн хүн харилцан биедээ дэмжиж туслах заавал мөнгөөр солилцоо хийхгүйгээр би одоо жишээ нь Мөнх-Эрдэнэ гэдэг хүнд тусалж дэмжээд байж байхад. Мөнх-Эрдэнэ намайг намаржаанд нүүхэд туслаад байж байх жишээтэй. Харилцан бие биенийгээ гээд явдаг энэ нь үр хойшдоо хүртэл аа эсвэл хүн хэн нэгэнд гэм хор хийхгүйгээр муудалцахаас зайлсхийгээд харьцахаа болиод өөр тийшээ явчихдаг. Ийм сэтгэлгээний онцлог байгаад байна. Moral economy гэдэг бол хүн дээр суурилсан гэр бүл дээр суурилсан эдийн засгийн болоод харилцаа явж байх жишээтэй. Гэтэл нөгөө зах зээлийн утгаараа явж байгаа Улаанбаатарт хотод ялангуяа зах зээлийн та 10000 төгрөг өг тэгвэл ингэнэ гэсэн энэ харилцаа давамгайлсан энэ хотожсон гэдэг юм уу энэ орчинд нөгөө итгэл үнэмшлийн маань Moral economy гэж бид нар яриад буй харилцан тусалдаг тэр орчин байхгүй болж байна. Тэр орчин байхгүй болохоор нөгөө хүн маань яалт ч аргагүй энд байгаа итгэл үнэмшлийг дагахаас өөр аргагүй болж байна. Энийгээ бид нар соёлын орчин гэх юм уу? юу гэхийн. Тэр хүний зөрчигдөж байгаа соёлын эрх гэдэг юмыг л бид нар ярьж байгаа шүү. Тэгэхээр тэр хүн ямар соёлтой юм бэ? хөдөө байхдаа итгэлцээд явдаг юм бол байна. Магадгүй Улаанбаатар хотод бас зарим хүмүүст нь байгаа байх. Сайхан найзалж нөхөрлөөд туслаад явдаг, харин энийг бол авлигатай бол хутгаж болохгүй. Шал өөр ойлголт. Гэтэл тэр нөгөө хүн тэнд сайхан бие биедээ туслаад явж байхад тэнд нэг уурхай орж ирээд тэндэх амьдрал орвонгоороо өөрчлөгдлөө гэж саная. Асар их cash economy буюу бэлэн мөнгөний арилжаа хийдэг ийм ертөнц бий болчихвол нөгөө хүн маань сайхан ээж аав ах гээд явдаг байсан харилцаа нь сүйрээд алга болж байна.

Заавал тийм байх албагүй болно гэсэн санаа байна уу?

Тэгээд мөнгөн дээр тогтсон харилцаа илүү давамгайлаад нөгөө хүн хүндээ итгэх итгэлцэл байхгүй болоод энэнээсээ шалтгаалаад нөгөө уламжлалт найр хурим нь өөрчлөгдөөд эхэлж байгаа юм. Энийг тэгвэл бид нар зөрчигдсөн соёлын эрх гэж харах юм уу?. Магадгүй энийг хүмүүс тэгж харах байх нэг их буруудах ч гүй байх гэхдээ нөлөө үзүүлж байгаа субъект нь гадны компани юм уу? зах зээлд худалдаа арилжаа хийж байгаа хүн юм уу? TINS юм уу үндэстэн дамнасан корпорацын нөлөөлөл гэж үзэх юм уу? тэнд байсан хүмүүсийн амьдрах аргыг л өөрчилж байна ш дээ. Тэгэхээр бид хоёрын түрүү ярьсан энэтхэгийн колончиллоос ялгах юм байгаа юм уу?. Гаднаас нь харахад ер нь өөр нэг нөхөр орж ирсэн, магадгүй зүгээр тэр үед цэрэг зэр зэвсэг барьж байсан бол одоо мөнгө бариад ороод ирлээ ш дээ. Тэгээд таны үйлчилгээ таны юмыг би арилжааны зориулалтаар танд тэдийг өгье, та эрхээсээ татгалз гээд санал тавьж байгаа байхгүй юу. Дуугүй татгалзаад тэр мөнгийг аваад тэр системийн нэг хэсэг болоод явж байна гэсэн үг. Тэгснээрээ тэр хүн уламжлалт байдлаараа амьдарч байсан тэр юм алга болж байна. Тухайн үед өөрчлөгдөж байгаа гэдгээ хүн мэддэггүй тодорхой хугацаа буюу тав арван жил өнгөрөөд эхлэхээр манай нутаг ийм ийм юмтай сайхан байсан. Одоо тэгсэн чинь ийм болчихлоо гээд аюулын харанга дэлдээд эхэлж байгаа юм. Одоо Монгол бол яг энэ процесс дээр явж байна гэж би үзэж байна. Урьд нь бол transformation буюу хувирал өөрчлөлтүүд зэрэгцээд яваад байсан тэгж байгаад нэг харсан чинь хүүшээ бид арван жил хорин жилийн өмнө ийм байсан ч дээ, бид нарын хүн чанар яасан бэ? бид нар одоо яагаад ингээд худгаа цоожлоод явдаг болчиховоо?. Бид нар орон гэрээ онгорхой орхиод явуулын хүн орж ирээд хоол унд хийгээд идээрэй гэдэг байсан одоо бол хулгай зэлгий ихэсчихлээ. Одоо энэ дээр хэн хариуцлага хүлээхийн энэ дээр нөгөө соёлын эрх зөрчигдөөд уламжлалт байдлаар хүн хүндээ итгэдэг зүйл алга боллоо гэж хэнтэй хариуцлага тооцох бэ? Төртэй юм уу? эсвэл transnational корпорац юм уу?, олон улсын байгуулга юм уу?, эсвэл хөгжлийн хөтөлбөр юм уу? Эсвэл нөгөө сүүлд ардчилсан хувьсгал хийсэн хүмүүстэй бид хариуцлага тооцох уу?. Эсвэл зүв зүгээр байсан бүгдээрээ ядуу дорой байсан тэр социалист нийгмээ буцааж авчрах гээд байгаа юм уу? тэгэхээр энэ чинь өөрөө ийм асуудалтай сэдэв байгаа байхгүй юу. Тэгэхээр соёлын эрх гэдэг зүйл зөрчигдөж байна уу гэхээр зөрчигдөж байна. Энэ бол тодорхой байна.

Тодорхой жишээнүүд олон нийтийн дунд яригддаг зарим судалгааны тайлан дээр байдаг. Жнь: Эмэгтэйчүүд овоон дээр гардаггүй, шагайн харваа, бөхөд оролцдоггүй, манайд хамгийн их яригддаг зүйл бол хурдан морь унадаг хүүхдийн асуудал гэх мэт иймэрхүү тодорхой жишээнүүдийг олон улсын байгууллага тайлан болоод зарим нэг хуульч өмгөөлөгч нар ярьдаг. Иймэрхүү тодорхой жишээнүүд дээр хоёулаа ярих уу?

Жишээнүүд чинь мэдээж судалгаан дээр тулгуурлан гаргаж ирэх ёстой. Хурдан морины хүүхдийн талаар зүгээр миний хувийн бодол шүү, судалгаа хийсэнгүй зүгээр ерөнхийд нь харахаар хурдан морь гээд унаад байж байхад соёлын эрх зөрчигдөж байна уу? хүний эрх зөрчигдөж байна уу? хүүхдийн эрх зөрчигдөж байна уу? ээд маш том discourse болоод маргаан мэтгэлцээн болоод хууль гээд явж байна. Цаад тал нь жендэрийн асуудал яригдаж байна. Энэ дээр баян хоосонгийн ялгаа гарч ирээд тэгш бусын асуудлууд яригдаж байгаа. Яахаараа хөрөнгө чинээлэг айлын хүүхдүүд нь морио унадаггүй мөртлөө хөрөнгө чинээ багатай айлын хүүхдүүд нь морио унаад, бэртээд байдаг гэх мэтчилэн энэ асуудлууд яригдаж байна. Бид нар энэ дээр нэг юмыг тодорхой бас энэ үед ярихаас өөр аргагүй. Universal буюу Хүний эрхийн түгээмэл тунхаглал гэдэг зүйлийг бид нар арай өөрөөр авч үзэх хэрэгтэй. Тэрийг бид нар хүндэтгэхээс өөр арга алга. Дэлхий нийтээрээ хүнийг амьд явах эрхтэй, хүний түгээмэл эрхүүдийг бүгдийг нь заагаад өгчихсөн. Энэ дотор чинь: хүн өөрийнхөө соёлоо амьдралдаа хэрэгжүүлээд итгэл үнэмшил зан заншлаараа явах эрхтэй гээд заагаад оруулсан. Энэ бүх юмнуудыг Нэгдүгээрт тулгуур зарчим яалт ч үгүй дэмжиж энийг хүлээн зөвшөөрөхөөс өөр арга байхгүй . Энэ дотор хүүхэд үхэж байхад тэрэн дээр асуудал ярихад хэцүү. Хүүхэд ямар нэгэн байдлаар гэмтээд хохирч байгаа бол энэ систем нь морин уралдаан уралддаг цаанаасаа тийм юм нь хөтөлдөг бол modify буюу засаж залруулах хэрэгтэй өөр арга байхгүй. Тэгээд хүүхдүүдээ зун болгон хэдэн зуугаар нь бэртэж гэмтээлгээд ингээд байж болохгүй энийг соёл гэж хэлж болохгүй. Соёл байна уламжлал байна гэхдээ тэрэн дотор өнөөгийн нөхцөлд таарсан засал юмнуудыг нь дотор нь оруулж шигтгэж өгөх ёстой. Энэ зүйлд хүүхэд өртөж болохгүй. Энэ соёлоо гээд чулуу шидээд эмэгтэй хүнийг алж байхыг соёл гэж хэлж болохгүй, яг тэрэнтэй адилхан морин уралдаан дээр хатуу зогсох хэрэгтэй. Ямар ч анторпологич хэн ч байсан тэнд хүүхэд нас барж болохгүй. Бэртэж гэмтэхгүй байдлыг дээд зэргээр хангах хэрэгтэй. Хэрвээ бэртэл

гарах тохиолдол нь их байгаад байвал сургалтад суух хэрэгтэй, тэр хүүхэд морин дээр яаж явахын аюулгүй байдлыг нь хангаж өгөх нь зүйтэй. Ингээд сертификат авсан хурдан морь унаачийг гадныхантай адил хүмүүсийг бэлдэлдээ тэгээд уралдуул. Үнэхээр тэгж уралдуулах дуртай байгаа юм бол, тэр хүүхдүүд туршлагагүй байгаад байна тэгээд унаад байна, тэгээд бэртээд байна нас бараад байна, энэ бүхнийг бол соёл гэдэг юмаар хаацайлж болохгүй . Хоёрдугаарт бөх сур харваа гэх зэрэг дээр хүний түгээмэл эрхийг нь заяагдмал эрхийг нь зөрчихгүй байвал болно. Тэгээд эрэмбэ дарааллаар нь бодох ёстой. Чулуу шидэж алдаг л байж болохгүй. Ямар ч нөхцөлд. Гэхдээ бид нар ийм аймаар extreme юм ярихаасаа өмнө хохирч байгаа хүн хэн байна нөгөө талд хохироогоод ашиг олж байгаа хүн нь хэн байна гэдгийг сайн мөрдөх ёстой. Эрхийг эдэлж байгаа хүн байна эрхийг зөрчүүлээд байгаа нэг хүн байна гэсэн үг. Заавал ч байхгүй danger хоёр хуваагдсан зүйл гарах гээд байна.

Энд нэг хүүхэд байсан чинь алив чи морь унаадах гээд байгаа юм уу?

Тэр хүүхдийг ямар ч байсан морь унуулчихсан л байгаа байхгүй юу. Нийтээрээ соёлын уламжлал байна жоохон хүүхэд нь морь унаад уралддаг. Магадгүй томчууд нь морь унаж уралдаж байгаад хүүхдүүдээ унуулаад түрүүлээд байхаар нь жаахан хүүхдээ уралдуулдаг болсон байж болно. Заавал хүүхэд гэсэн дүрэм журам байхгүй. Соёл гэдэг чинь өөрөө тухайн цаг үеэсээ шалтгаалаад өөрчлөгдөн хувьсаж байдаг зүйл. Соёл гэдэг тухайн цаг үедээ нийцээд өөрөө өөрийгөө эвтэйхэн болгодог, хөгжин гэж хэлэхэд хаашаа юм өөрөө тэр үедээ зохицоод уян налархай явдаг. Тэгэхээр тэр соёлын явах боломжийг нь бид нар хангах ёстой дандаа эрх гэдэг талаас нь харахын оронд тэр соёл дээр.

Эмэгтэйчүүдийн асуудал дээр та ямар санаа илэрхийлмээр байна? Энэ бол арай өөр зүйл түрүүний хэлж байгаа шиг зарим нэг зан үйл ёслолд оролцдоггүй гээд байгаа мэдээж тодорхой баримт байхгүй гэхдээ одоогийнхоор бол тэгээд байгаа. Эмэгтэй хүний эрх гэдэг эрхээ онцолж ярих юм уу? хүний эрхээ мэдээж дээр нь тавьж байгаад хэр harmful хэр их хор хохиролтой вэ гэдгээр эрэмбэлэгдээд явсан нь дээр үү?

Соёлыг маш зөвөөр тайлан таниулах хэрэгтэй. Эмэгтэй хүн яагаад овоон дээр гардаггүй юм бэ? Энийг шал өөрөөр тайлбарласан эмэгтэй хүнийг ялгаварлан гадуурхаад байгаа юм шиг сонсогдоод байгаа юм. Би бол бурхны шашны маягтай эрээвэр хураавар саарал тийм тайлбарт дургүй. Эмэгтэй хүн сарын тэмдэг юм ирж байгаа учир бузар ч гэж байх шиг. Уучлаарай тийм юм байхгүй. Монголын уугуул соёл бол миний заалгаж байснаар Нямбуу гуай Дулам багш Цэрэнханд багш нараар би 90 онд угсаатны зүй судалгааг заалгаж байсан. Миний уншиж байсан Чой Лувсанжав гэдэг хүн надад зааж байсан. Ингээд тэд нарын хамгийн гол ярьдаг бол эмэгтэй хүний умай тэрийг бүр шүтдэг. Тэр чин өөрөө алтан сав гэдэг үр үндэс тээдэг тийм юмнуудыг хэлж байгаа юм. Бид нар тэрийгээ бодож тэгж тайлбарлавал тайлбар нь шал өөр болно. Эмэгтэй хүн овоон дээр гарахаар бид нарын суурь шүтлэг бол Тэнгэр эцэг, Этүгэн эх гэж ярьдаг. Эмэгтэй хүн тэр уул нь дээр гараад байж байхад тэнд уул усны удган ч юм уу? харилцан ойлголцох ч гэдэг юм уу? угаасаа эмэгтэй хүн тэр уул усны эзэн савдаг учраас заавал шаардлагагүй гэдэг байдлаар тайлбарлаж яривал шал өөр зүйл гарна. Эмэгтэй хүн гэдэг эхийн бүх үржлийн бэлэгдэл нөөц баялгийн эх ундарга. Магадгүй тэр уул усны эзэн эмэгтэй бөө савдаг байж болно тийм учраас заавал гарах шаардлагагүй гэж тайлбарлавал шал өөр болно. Магадгүй тэр бөөгийн үзэл суртлаар бол эмэгтэй хүн гардаггүй газар гэж байхгүй болно. Магадгүй худлаа зохиосон зүйл.

Жишээ нь: Шагай харваа чинь уламжлалаараа бол төрийн наадам байгаагүй ш дээ. Саяхан л шагай харваа чинь ороод ирсэн. Гэтэл шагай харваанд эмэгтэй хүн оруулдаггүй гэдэг. Энэ нь олон улсын байгууллага, хүний эрхийн бодлоороо бол эрхийн зөрчиж байгаа юм. Ахуйн наадгайгаараа л байсан зүйл төрийн наадмын хөтөлбөр болчихлоо. Тэгэхдээ эмэгтэйчүүдийг оруулахгүй. Ингэхээр хүний эрхийн зөрчил шиг харагдаад байна.

Тэр судалгааг сайн хийх ёстой. Би Архангай аймагт явж байдлаа сонсон мөсний шагай харваа байдаг. Магадгүй тэр шагайнуудын тас няс хийх чимээ нь буг чөтгөрийг үргээдэг гэлцдэг. Тэрэнд эмэгтэй хүнийг оролцуулдаггүй тэр нь ялгаварлан гадуурхалт юм шиг, хэрнээ цаанаа эмэгтэй хүнийг хайрлаж байгаа, хамгаалж байгаа нь. Магадгүй тэр овооны асуудал эмэгтэйчүүдийг хамгаалах

үүднээс хийж буй үйлдэл байж болно. Тэгэхээр соёл гэдэг зүйлийг яаж аль өнцгөөс харж тайлбарлах вэ? гэдэг нь өөрөө хамгийн маргаан дагуулсан. Ялангуяа энэ дээр түүхчид хамгийн сайн анхаарах хэрэгтэй. Түүхчид дандаа болохгүй racist юм уу entocenter үзлийг өөрсдийнхөө яс үндэс угсааг нэгдүгээрт тавьсан хараад бусдыг нь доошоо харсан байдлаар бичдэг. Тэгж хараад бичнэ, тэр нь үлдчихээр тэрийг нь хожмын нэг судлаач туйлын үнэн мэтээр аваад үзчихдэг. Тэгээд энийгээ зөвтгөж тайлбарлаагүй болохоор энэ нь сүүлдээ буруу ойлголт төрүүлж байгаа. Тэгээд ерөөсөө эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөөд байсан юм шиг л магадгүй эсрэгээрээ байж болно. Дээр нь эмэгтэйчүүдээ хайрлаж хамгаалж байсан зүйл байж болно. Яагаад нээлттэй байж болохгүй гэж соёл гэдэг юм чинь өөрөө хувьсан өөрчлөгдөөд явдаг зүйл. Казакстанд хүртэл эмэгтэй бөх барилдаж байна. Яг манай Монгол барилддаг байсан дээр үедээ барилддаг байсан нь үлдчихсэн Казакстанд бөх барилдаж байна судлаач нь хүртэл надтай ирээд уулзлаа. “Яагаад вэ? Монголд чин угаасаа эмэгтэй бөх барилддаг байсан тэр чин манай Казакстанд Киргизээр дамжин манайд үлдчихсэн гэтэл танайд яасан юм бэ?” яагаад би энийг судалмаар байна гээд ирсэн. тухайн үеийн ideology юм уу? эзэн хаан ч юм уу? хэн байдаг юм нэг нөхөр өөрт ашигтай зүйлийг тэр дотор жижигхэн засал чимэглэл оруулсан байгаа байх. Энэ нь туйлыг үнэн мэтээр шашны хоорондын тэмцлээс улбаатай ийм явуулж байсан ч байж болсон. Манайх чин эмэгтэйчүүдийн эрхийг нээлттэй байх хүндэтгэх тал дээр бол хамгийн нээлтэй ард шүү дээ. Хамгийн ер нь нээлттэй, нэг талдаа хэт хялбаршуулсан байдлаар харж байхад тэр дотор байдаг олон зүйл байдаг.

Энэ дээрээс ургуулаад миний дараагийн асуулт бол цөөнх соёлын эрхээ ингэж илэрхийлэх гэхээр зан заншил дуу бүжиг эд нар нь ингэж хязгаарлагддаг тохиолдол бий юу? Манайд казакууд байна, бас тува нар гэх үү? цаатан гэх үү?, бас нэг хэсэг тува хүмүүс байгаад байна. Манайхан бол Монголдоо оруулаад байх шиг байна. Тэгэхдээ тэд нар чинь угсаатны цөөнх гэж үзье. Ингэвэл энэ гурав соёлынхоо өвийг дэлгэрүүлэхэд тулгардаг бэрхшээл асуудал байх уу?

Би бол ингэж үзмээр байна. Энэ бол хэлний цөөнхүүд шүү дээ the minority. Цөөнхийн бүлэг ялангуяа цөөнх доторх цөөнх шүү дээ. Урд нь яагаад ч юм 90 оны үед nationalist үзэл газар авлаа ш дээ. Тэр бол юутай холбоотой гэхээр социализмын үед зөвлөлтийн ideology дор дарлуулсан ард чинь үндэс угсаагаа

сэргээх давлагаа ирээд эхэлсэн. Маш хүчтэй явсан тэр нь 1986 1987 оноос эхлээд Батмөнх гуай гарч ирээд маш зөөллөсний дараагаар гарч эхэлсэн. Япончуудтай нийлээд нууц товчооныхоо дагуу Чингис хааны шарилыг хайгаад л ингээд нэг тэр үед нэг давлагаа явсан байдаг юм. Яг тэр давлагааны дараа гарсан бүтээгдэхүүн нь бол би байхгүй юу. 1994 онд дээд сургууль төгсөөд тэрнээс өмнө ганзагын наймаа гээд явсан. Тэгээд Монгол бичгээ сэргээнэ гээд баахан юм явж байгаад яалт ч гүй гадны эдийн засагт бид нар цохиулсан байхгүй.

Нөгөө эдийн засгийн хямрал дайраад ардчилсан хувьсгалын эхэнд бичиж байсан юмнуудыг, Баабарын бүү март сана гээд бид нар санаж байгаа биз дээ гуйлгын тулам болсон гээд аюугүй их шүүмжлэлтэй хандаж байсан. Яалт ч үгүй дараа нь 90 он гараад эдийн засгийн хямрал бүр доороо тулаад юун нөгөө угсаа гарал ярих яаж амьд үлдэх бэ? гээд тэр үед их хүмүүс тэр үндэс угсаанаасаа буцсан байдаг. Тэгээд нөгөө гуйлгын тулам гээд яриад байсан нөгөө Баабар чинь гадаадаас мөнгөн тусламж гуйх яг нөгөө ажил дээр жинхэнэ дайчлагдаад явж байсан. Тэгээд тэр үзэл суртлаасаа буцсан яалт ч үгүй зээлээр хөгжихөөс өөр арга байхгүй юм байна гээд тэгээд тэр талаар дахиж яриагүй. За дээрээс нь соёлтой холбоотойгоор 90 онд нэг давлагаа яваад 2000 он гээд баахан зуд турхан болоод уул уурхай гадныхан орж ирээд дараа дахиад 2005, 2006 онд дахин нэг давлагаа гарч эхэлж байгаа юм. За тэрэн дээр бид үндэстэн улс өөрсдөө шийдвэрээ гаргах ёстой, тэрний цаана байгаль орчноо хамгаалах гээд дандаа соёлууд яригдаж байгаа . Гурав дах давлагаа яалт ч байхгүй 2015 2016 оноос гарч эхэлсэн. Энд нэг залуучууд гарч ирээд одоогийн ерөнхий сайд болоод тухайн үед баруунд гарсан тодорхой хэмжээний мэргэжил эзэмшсэн тэгэхдээ бас Монголоо дээшлүүлэх хэрэгтэй гээд Удирдлагын академи гээд судлаачидтай хамтраад 20/50 гэдэг аргачлал гаргалаа энд нь зөвлөсөн оролцсон асар олон хүмүүс байдаг юм байна лээ. 20/50 бол харьцангуй гайгүй nationalist утгаасаа эерэг утгаараа баримт бичиг болсон.

Ингээд Монголынхоо үндэс угсаа яс соёлыг аваад явъя гээд гурван давлагаа гарсан байгаа юм. Яг энэ гурван давлагаатай холбоотой яг энэ ярьж байгаа асуудал чинь сөхөгдөж гарч ирж байгаа юм. Эхний давлагаан дээр болохоор энэ дээр үндэс угсаагаа сэргээх гээд гарч ирэх үед яг энд хуваагдлын асуудал гарч ирсэн. Дөрвөд баяд казак гээд хуваагдах гээд эхлэх үед аз гэхийн муу эдийн засгийн шок гарч ирээд нам дарсан. Та нар Монгол байна уу? казак

байна уу? ер хамаа байхгүй эхлээд амьдраадах эдийн засгаа сэргээ тэгээд больё гээд дарчихсан. Дараа нь 2000 гараад юм нэг тогтвортой болоод ирэх үед яалт ч байхгүй казахстан талаас баахан дүрвэж явсан ирсэн гээд баахан хүмүү Туркийн нөлөө Казахстаны нөлөө орж эхэлсэн. Сүм мича билүү хүмүүсийн зүрх гээд тэнд нэг юм явж байгаа юм хөөрхий минь тэр үед бас эдийн засгийн амьдрал нь хамгийн гол тодорхойлогч хүчин зүйл байсан. Тэрэн дээр айхтар их юм гараагүй. Монголоос очсон хэдэн казакууд тэнд хашигдаж хавчигдаад жаахан тийм юм болсон. За ингээд эхлэхээр тэр ялгаварлын асуудал гарахгүй явчихаж байгаа юм. Бүгдээ ядуу гадагшаа зорьж явж ирээд бид чинь харин энд жаргадаг юм байна гээд. Бид чинь эх орондоо жаргадаг байж гээд, харин ч энэ асуудал бол цаатан иргэдэд бол огт нөлөөлөөгүй.

Харин цаатан иргэдийн хувьд ардчилал гараад 2000 он гарснаас хойш жуулчид тасраагүй. Тодорхой хэмжээнд амьжиргаа нь дээшлээд эхэлсэн. Социализмын үед гарч байгаагүй сонин юмнууд аваад зарим нь бүр суурьших маягтай болж эхэлсэн ер нь цаа маагаар ер нь яадгийн гээд би бол тэгж ойлгодог. 2000 оны үед энэ тэрээ гарсан боловч тэр үед амьдрал нь бол тааруу байсан. Энэ үед яасан гэхээр нөгөө гадны төслүүд маань хүний эрхийн төлөөлдөө сайн сайхан зүйл хүсэж мөрөөдөж гадны төслүүд орж ирнэ л дээ. Ингээд яг цаатан иргэдийн эрхийн асуудлыг 2005 2006 оноос ярьж эхэлсэн байдаг юм. Тэгээд хамгийн эхлээд засгийн газрын тогтоол гаргаад дараа нь ерөнхийлөгчийн тогтоол энэ тэр гаргаад Элбэгдоржийн үед тодорхой мөнгө төгрөг өгье гээд энэний цаад талд бас нэг хөгжлийн төслүүд үнэ ажилласан. UNFPA ажилласан учраас л тийм санаачилга гарсан түүнээс биш Монголын төр ганцаараа бол хийсэн гэж би бол итгэхгүй байна. Казахстаны хувьд казах иргэдийн хувьд үзэхээр айхтар зөрчил бол харагдаагүй. Тэнд гэр бүл өсөж үржээд олшроод мал нь өсөөд сайхан явж байгаа ард түмэн. Тэд нарын хувьд гадны нөлөө бол нэлээд орж ирсэн, нөлөө орсон учраас нэлээн ч их өссөн 2000 он 2009, 2010 онуудад Баян-Өлгий рүү орохоор өөр гадны улс руу орж байгаа ч юм шиг тийм байдал орсон. Энэ байдлууд бол магадгүй үндэсний аюулгүй байдлын хэмжээнд яригдсан л байх харин иргэдийн түвшинд очихоор бол тэнд ямар ч асуудал байхгүй. Гэхдээ яг иргэдийн түвшинд бол тийм асуудал ердөө байхгүй.

Сүүлийн үеийн хэвлэл мэдээллээр яригдаж байгаа асуудал бол казах хүүхдүүд Монгол хэл мэдэхгүй байна гэсэн асуудал гарч ирсэн, би одоо

тэнд төрсөн казак хүүхэд байгаад Монгол хэл мэдэхгүй байлаа гэе. Миний амьдрах орон зай маш хязгаарлагдмал, магадгүй би нэг бол Казакстанд эсвэл Баян-Өлгий аймагт л амьдрах байх. Энэ одоо бид хоёрын ярьж байгаа соёлын, нийгмийн, эдийн засгийн эрх гэх мэт зүйлстэй холбогдох боломжтой юу? Жишээ нь МУИС-д сурч чадахгүй нь байна. Багшаа би мэдэхгүй ээ гээл байдаг. Манайд бол яг ийм оюутнууд байна, би ийм хоёр оюутантай таарлаа.

Энэ бол яг бид нарын санаа зовж байгаа асуудал. Бас дахиад магтан сайшаах уу? эсвэл яах вэ гэсэн. Энэ нь бас л тэр гадны төслүүд маань ороод ирчихсэн. Цөөнхийн эрхийг бид нар дэмжих ёстой гэсэн. Ямар нэгэн онолоос гаралтай том давалгаанууд “ Тогтвортой хөгжил”, “Мянганы хөгжил”, “Цөөнхийн эрх” “Уугуул иргэдийн эрх” зэрэг том давалгаа гарахаар түүний хаялга чичиргээн дээр энэ төсөл нь заавал Монгол дээр орж ирдэг. За тэгээд тэр төсөл дээр НҮБ , Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк гэх мэт байгууллагууд тэр том давлгааг харж байгаад шийдвэр гаргагч бодлого тодорхойлогч нар шийдээд мөнгө хувиарлангуут тэр мөнгөн дээр алалцаж ороод л тодорхой төслийг хэрэгжүүлэх нэрээр ордог. Жишээ нь Монголыг хариуцсан хүн бол тэнд том төслүүд батлагдвал аль болох монгол руу авч ирэхийг бодно, жендерийн холбоотой асуудлууд ч юм уу, хөгжлийн анторпологиин юмнуудыг ярьж байна. Тэгээд ингэж оруулж ирсний үр дүнд тэнд манайхан өөрчлөлт хийчихсэн ш дээ. Өөрсдийнхөө хэл дээр сурах эрхтэй мэдээж өөрсдийн төрөлх хэл дээр сурах хэрэгтэй мэдээж хосолсон хэл байх юм уу? нэг нь дангаараа байх юм уу?, гэдгийг бид нар нухацтай бодох ёстой.

Тэгэхээр тэр хүнд чинь ерөөсөө сонголтын хязгаарлачихаж байгаа хэрэг болох уу. Эсвэл казакаар ярьдаг тийшээ яв тэр нь Казкастан эсвэл Баян-Өлгйдөө үлд. Чи монгол хэл мэдэхгүй учир монгол хэлтэй энэ орон зайд орж ирж болохгүй. Ер нь тэр бол монгол улсын иргэн байгаад байдаг. Өмнө байсан дэлгэр гэдгийн муу тэр боломжийг нарийвчлаад хаачхаж байгаа юм. Тэгэхээр наадах чинь болохоор countorprotecting буюу өөрсдийнхөн тооцоолоогүй сөрөг үр дүн гарчихсан байхгүй юу, энийг тэр энийг санаачилж боловсролын системд орж ирүүлсэн хүмүүс өөрсдөө хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Үнэхээр хүүхдэд Казак хэлээ ч сурдаг Монгол хэлээ ч мэддэг байж байж цааш суралцана. Монголын чинь албан ёсны хэл бол Монгол, гэхдээ цөөнхөд бид тэр

Монгол хэлээрээ ярьж бичих боломж олгох ёстой гээд үндсэн хуульд заачихсан. Аа тэгэхээр тэр хүнийг бид нар хорлож байгаа хэрэг болж байгаа юм.

Урд зүгийг бид нар харья л даа. Өвөр Монгол бол хос хэлээр явдаг байсан. Хос хэлээрээ явдаг Монгол хэлээ ч сурдаг тэр хүүхэд хос морьтой байсан. Одоо бүр бүүр монгол хэлийн тас хориод одоо зөвхөн хятад хэл зааж байна гэнэ. Харин бид нар бол эсрэг бүр нөгөө хязгаар монгол хэл заахгүй зөвхөн казак хэл заагаад, энэ чинь өөрөө соёлын эрхийг хүний тэр боломжоос хүртэх эрхийг нь хязгаарласан бодлого болж байна. Ингийгээ манайхан сайн бодож ер нь бол тэр хүүхдийг хос хэлтэй болж байж цаашаа бололцоо боломж нь нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл баахан Монгол хэл ойлгодоггүй ,төрийнхөө зурагт радиогоор ярьж байгаа мэдээ мэдээллийг ойлгодоггүй соёлын давамгайлалд цаад талаасаа өртөөд ирэхээр нөгөө хүн чинь оюун сэтгэлгээ чинь өөрчлөгдөөд хуваагдал үүсдэг. Ийм учраас энийг үндэсний аюулгүй байдлын түвшинд гэдэг юм уу соёлын эрхийн хүрээнд сайн бодож тунгаах ёстой. Тэр хүнийг нэг талдаа сайжруулж байгаа юм шиг мөртлөө нөгөө талдаа хуваагдал үүсгэдэг.

Энэ чинь америкт байгаа индиануудын хүүхдүүдийг яасын, австралид бас хүүхдүүдийг яасын, нөгөө уугуул иргэдийн хүүхдүүдийг хүчээр татаж авчраад хүчээр католик сургуульд явуулсан. Христийн сургуульд сургаад шашны соёлын мартуулж байгаа байхгүй юу. Тэр америк европт асар ихээр явсан, урд зүгт явж байна. Хойд зүгт бас явсан . Аан гэтэл бид нар бол харин эсрэгээр нь хийж байна. Эрхийн дэмжиж байна гэсэн нэрээр хүүхдийн зөвхөн индианаар л ярьдаг тэндээ л амьдардаг гадуур нь төмөр хашаа бариад хашчихсан юм шиг шорон шиг газар амьдралыг өгч байгаа байхгүй юу. Тийм л дүрэм тогтоочихож байна. Дараа нь тэр төмөр хашаан дотор байсан хүн хэн нэгэнтэй холбоо тогтоовол наашаагаа салган бутаргах гэсэн л арга. Өөр бусад соёл нэвтрэлцэхгүй байгаа юм яахын.

Магадгүй хууль эрхзүйн үүднээс бол шийдвэр гаргахад хуулиа барьдаг. Гэтэл хүн шийдвэр гаргахдаа тэр бүр хууль харж хийхгүй. Тэр битгий хэл төрийн албан хаагч хүртэл, эндээс юм сонсон тэндээс нэг юм харна тэгээд магадгүй хуулиа уншина. За боллоо гэсэн үедээ шийдвэр гаргана . Ингээд яриа болно хэлэлцүүлэг болно, хүмүүст нөлөөлнө эцэстээ тэгээд яг үнэндээ хуульчдын ярьж байгаагаар хууль энийг зохион байгуулалтад оруулаад байгаа гээд боловч анторпологичдын яриад байгаа энд байгаа баахан юмнууд нийлж байгаад юм үүсгэж байна. Хүний эрхийн зөрчил гэж

ярихаар хуульчид болохоор төр л зөрчих гэж ярьж байгаа ш дээ, гэтэл магадгүй түрүүний ярьж байгаа шиг олон улсын байгуулга байвал яахын, эсвэл нөгөө шашны төлөөлөгч байвал яахын гэсэн юм үүсэх үү.

Тэгэхээр хэдүүлээ хамгийн энгийн жишээ харья л даа. Малчид малаа өсгөж байна. Үнэхээр Монголын мал өсөж байна. Тэгээд идэж уудаг өвсөн дээрээ дарамт учруулалгүй яахав дээ. Тэр бол ойлгомжтой, ядаж дээр нь гишгэлээд байгаа юм чинь ямар олигтой л ургав гэж. Гэтэл туйлын ганц өвсөнд нөлөөлж байгаа нөлөөллийг малаар тооцоод бусад зүйлүүд дээр анхаарлаа бага хандуулаад, бусад нөлөөллийг тооцохгүй байна шүү. Уур амьсгалын өөрчлөлт гэдэг юм уу элдэв янзын зүйлс байна ш дээ, иймэрхүү зүйл дээр хэт нэг талыг барьсан онол сэтгэлгээг улсаараа дэмжээд тэр нь хэт нэг талыг бариад итгээд явчихаар тэрний цаад талд нь асар их үр дагавар гараад байгаа байхгүй юу. Тэгэхээр бүгд мал чинь маш хэрэггүй юм байна энэ байгалийг байхгүй болгож байна. Монголын онгон дагшин байгалийг байхгүй болголоо. Энэ нэг сувдаг сэтгэлтэй нөхдүүд гээд энэ чинь өөрөө талцлыг бий болгож байгаа юм. Мэдээж талцал өөрөө хаана үүсдэг бэ? гэхээр арай нэг жаахан юм уншдаг гэдэг юм уу шийдвэр гаргах түвшний тэр хүмүүс дунд талцал үүсэж байгаа юм. Энэ нь газар аваад энгийн иргэд дунд тархаж байгаа юм . Энэ чинь өөрөө харин ч нөгөө соёлын эрхийг зөрчихөд шууд хөтөлж байна.

Гэтэл яс юм дээр өвс ургахад хамгийн их нөлөөлдөг зүйл бол хурд тунадас температур хоёр шүү дээ. Гэтэл энэ нь өөрөө Монголын уур амьсгалын газар нутгийн 70 80% нь хагас хуурай, хуурай уур амьсгалтай байсаар байтал энэ өвсийг баруун европын төв европын сахалга өвстэй харьцуулаад байгаа юм. Ийм байх ёстой юмыг энэ 60 70 сая мал байхгүй болгочихлоо, малчид гэж хувиа хичээсэн хогийн хүмүүс байна гээд тэд нарын амьдрах эрх рүү шууд халдаж эхэлж байна. Нөгөө хүмүүс маань малчин ард гэдгээсээ ичээд эхлэлээ. Малчдыг үзэх нийгмийн конструктор үзэн ядах сэтгэлгээ үүсээд энэ нь өөрөө цаад талдаа маш олон юмыг байхгүй болгож байгаа юм. Тэд нарын амьдрах арга хэлбэр ,соёл зан заншил авч явах уламжлалт маягаараа сүү цагаан идээгээ боловсруулах, уналга ачиллага авч явах гээд маш олон зүйлс байхгүй болж байгаа юм. Тэгээд морины тухай мотоциклийн тухай юм ярьдаг.

Энэ дээр ганц жишээ яриад дуусгая. Малчид чинь одоо залхуу болсон морио унаж байвал энэ хүмүүсийн соёл тэнд хадгалагдах юм шиг юм ярьж байна.

Мотоцикл унаад эд нар хүнээ байлаа байгалийг бохирдуулж байна, тэр хортой хий ялгаруулж байна. Тэгж байна гээд баахан юм ярьдаг тэгээд соёлоо харин байхгүй болгочихлоо гээд харин би энэ дээр өөр юм хэлмээр байна. Мотоцикл унаж байгаа тэр хүнд ерөөсөө буруу алга. Хүн яадгийн бэ? аль болох хөдөлмөрөө хөнгөвчлөхийг бодно нэгдүгээрт, хоёр дугаарт тэр мотоцикл гэдэг бол амар. Жишээ нь хүн морио адгуулаад явахын тулд өглөө 5 цагт босно морио барина. Чөдөрлөөд тавьсан морио наашлуулаад эмээллээд тавина. Адуундаа явдаг хүн бол бүр эрт босно. Тэгээд тэр дор хаяж нэг цагийн ажил хурдан хийлээ гэхэд 20, 30 минут болно. Тэгээд морио услаад идүүлээд тэгээд яваад нэг газар очиход 3 цаг болно. Ингээд очиход малаа наашлуулаад бариад бас хэдэн цагийн ажил харин мотоциклоор болохоор ерөөсөө маш хурдтай 5 минутын дотор асаагаад нөгөөдхөө наашлуулаад аваад ирж байна. Энэ хурдтай хөгжиж байгаа үед цаг хугацаа гэдэг бол алт, маш үнэтэй болоод хувирчихсан чоно дайрах ч гэдэг юм уу? гал ус үеэр гэдэг юм дээр нөгөө мотоцикл нь арай илүү байдаг. Ингэхээр нөгөө хүн маань хэрэглэнэ. Хоёрдугаарт тэр хүмүүс соёлоо Улаанбаатарт амьдарч байгаа миний хүсэл сонирхолд нийцүүлээд хөдөөг би багаасаа морьтой хүн малаа хариулдгаар төсөөлж өссөн миний хувийн аминчхан бодолд тохируулж морь унах ёсгүй. Технологийн дэвшлийг тэр хүн хүртэх эрхтэй ш дээ. Миний төсөөлөлд нийцүүлж тэр хүн амьдрах аргагүй. Соёл гэдэг чинь өөрөө хувьсаад хэрэгтэйгээ аваад хэрэггүйгээ хаядаг систем сайн нь үлдээд муу нь хаягдаад явдаг тэр дотор чинь маш олон хүн оролцдог. Энэ нь сайн байна гээд хувираад явах ёстой. Тэр бүхэн миний 3 ангид үзсэн номон дээр гардаг шиг амьдрах ёсгүй. Ийм юмнуудыг бид бодож ярих ёстой. Бидний ярьж байгаа зүйлсийг сонссон тэр хөдөөнийхөн өөрсдийгөө буруутай ч юм шиг аймар буруутай юм шиг. Хэдэн сэтгүүлч судлаач очихоороо та хэд морио унадаггүй мотоцикл унадаг гэхээр нөгөө малчин харин тиймээ гээд аймар буруутай хүн.

Очоод судлаад дотор нь ороод ярихаар морь унахаар тийм тийм юм байна. Мотоцикл унахаар тийм байна миний амьдралд ингэж нөлөөлж байна гэхээр арай өөр хүүхэд өвдлөө гэхэд сургууль соёлд хүргэх гээд, би 6 настай хүүхдээ 3 цаг мориор авч явсан дээр үү? мотоцикл дээр хорь гучхан минут яваад эмнэлэг орсон дээр үү? гээд. Аюулгүй байдлаасаа авхуулаад гэхээр морин дээрээс хүүхдүүд унаад үхжил байсан ч дээ тэрийг хэн ч бүртгэдэггүй байсан болохоос биш. Мотоцикл бас зөндөө олон хүн унаж нас барж байна. Ийм юман дээр бид нар нээлттэй байдлаар харж соёл зан заншлаа арай өөрөөр бодож

орчин үетэй хөл нийлүүлж соёл гэдэг чинь бид нарын хүссэн шиг 13 дугаар зуундаа гацаад үлдчихсэн зурган дээр байдаг шиг бишээ гэдгийг ойлгох хэрэгтэй. Нүүдлийн соёл чинь хөдөө ч байдаг хотод ч байна. Соёл гэдэг чинь хүний оюун ухаанд байдаг тэрийг бид нар хамтдаа бүтээгээд хөгжүүлээд аваад явдаг. Тэрний цаад талд үнэт зүйл сэтгэлгээний онцлог байна. Бид нар тэр өнцгөөс нь соёлын эрх гэдэг зүйлийг харах хэрэгтэй.

Одоо энэ салбарт ажиллаж судалгаа хийж байгаа экспертийн хувьд та ийм юм тусгавал зүгээр шүү гэж санал болгохоор юм юу байна вэ?

Тэгэхээр ерөөсөө соёлын тухай соёлын эрхийн тухай ярихаар төрийг ярихаас өөр арга байхгүй. Төр гэдэг чинь миний эрхээ эдлэхэд хангаж байх ёстой субъект байгаа юм. тэр нь орон нутгийн байна уу?, төвийн байна уу? хамаа байхгүй тэнд гарч байгаа бодлого шийдвэр л би өөрөө хүссэнээрээ амьдрах бололцоог хангасан нээлттэй байх ёстой. Саяны хэлний бодлого шиг дутуу дулимаг байж болохгүй, ирээдүйг бас харсан байх ёстой.

2 дугаарт нь энд оролцож байгаа оролцогчдыг зөвхөн төрөөр хязгаарлаж болохгүй. Тэнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаачин, тэнд ажиллаж байгаа шашны номлогч, уул уурхайн компани, тэнд үйл ажиллагаа явуулж байгаа байгаль хамгаалж байгаа байгууллага бүгдийг бид хараад оролцогч гэж үзнэ. Энэ дотор асуудлыг авч үзнэ. Энэ дотор ялангуяа нийгмийн хүрээнд би болж байгаа хэлэлцүүлэг ярианууд өөрөө асар их хор уршигтай. Энийг нүдэн балай чихэн дүлий юм шиг нэг талыг хэт барьсан ийм хэлэлцүүлгийг зурагт радиогоор судалгаагүйгээр яриад байх нь туйлын буруу болж хувирч юм. Тэгэхээр ийм юмнуудыг цаашдаа их болгоомжтой авч үзэх хэрэгтэй.